



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 16 өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕЙН ТАМИР, ДИЗАЙН
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Бүрэн дунд боловсрол X-XII анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

**Бүрэн дунд боловсрол XI анги
(Заавал болон сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар
2019

“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга, магистр

Багийн гишүүд

Монгол хэл:

М.Базаррагчаа

Б.Мөнгөнцэцэг

Б.Оюунцэцэг

Ц.Өнөрбаян

Ц.Туул

Б.Цасанчимэг

Ө.Цэндсүрэн

А.Энхнаран

Д.Эрдэнэсан

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Уран зохиол:

Г.Галбаяр

Ц.Март

Г.Нандинбилиг

П.Нармандах

П.Одсүрэн

Д.Туяа

С.Энхбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн эрхлэгч

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

Үндэсний бичиг:

Ү.Ариунболд

Д.Баттогтох

Б.Батчимэг

Н.Мөнхцэцэг

Д.Соронзон

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Хөндлөнгийн шинжээч:

А.Цог-Очир

Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ц.Оюун

Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Б.Сүхболд

ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ш.Оюунцэцэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл,
нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

**МОНГОЛ ХЭЛ
(Заавал судлах)**

УНШИХ

Суралцахуйн зорилтууд	Суралцахуй үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Эргэцүүлсэн эсээ, аян замын тэмдэглэл, шинжлэх ухааны хялбаршуулсан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог тайлбарлаж, сэдэв, гол санааг тодорхойлох</p>	<p>Эхийн сэдэв, гол санаа, агуулгын уялдаа холбоог тогтоох</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд бүхэлдээ юуны тухай өгүүлж байгааг тодорхойлох - Эхийг цогцолбор болон эхлэл, гол, төгсгөл хэсгээр зааглах - Эхийн доторх юмс, үзэгдлийн харьцаа, тэдгээрийн давтамжаас үүдэн цогцолбор тус бүрийн сэдэв ба гол санааг тодорхойлох - Тухайн эхийн сэдэв нь хэд хэдэн дэд сэдвээс, гол утга нь мөн хэд хэдэн утгаас бүрддэгийг задлан тайлбарлаж буй эхийн хэсгийн жишээгээр дүгнэж батлах <p>Эхийн агуулгын уялдаа холбоог тогтоох</p> <ul style="list-style-type: none"> - Агуулгыг бүрэлдүүлж буй хэсгүүдийн заагийг тодруулах - Тэдгээрийг утга санааны дарааллаар ангилах - Зохиогч хэрхэн төлөвлөсөн байж болохыг таамаглал дэвшүүлж тодорхойлох - Уншигчийн хувьд эхийн агуулгын хүрээнд төлөвлөгөө зохиох - Эхийн агуулгыг бүрэлдүүлж буй зонхилох өгүүлбэрүүдийн дотор өгүүлэгчийн эргэцүүлэн, шүүн дүгнэсэн утгыг илэрхийлэхэд голлох үүрэгтэй байгаа ямар ямар өгүүлбэрүүд байгаа, тэдгээр нь хоорондоо утгын хувьд хэрхэн уялдаж байгааг тодруулна. Тухайлбал: Одоо цаг бүхий баталсан өгүүлбэрүүд, бүтцийн хувьд төстэй өгүүлбэрүүд, үйл явдлыг хойно хойноосоо цувуулсан өгүүлбэрүүд, шинжийг тоочсон, үйл явдлыг хүүрнэсэн, юмс үзэгдлийг дүрсэлсэн, эргэцүүлэн баталсан, таамагласан, тайлбарласан өгүүлбэрүүд гэх мэтээр хэлэхүйн зорилгоор нь ялган цогцолбор бүрийн гол санааг хадгалсан тулгуур өгүүлбэрүүдийн утга санааны дарааллыг тодорхойлж болно. <p>Зөвлөмж <i>Эргэцүүлсэн эсээнд зохиогчийн бичлэгийн төрөл бүрийн арга барил холилдон ордгийг анхаарна. Тухайлбал: Юмын шинжийг тоочих, хэрэг явдлын өрнөлийг өгүүлэх, шинж, үйл байдлыг нэг цагт дүрслэх гэх мэт. Эдгээр нь зохиогчийн зүгээс дэвшүүлсэн асуудал, эхийн гол санааг бүтээхэд ямар үүрэгтэй байгааг тодруулан ажиглана.</i></p>	<p>-Б.Ринчен “Их говийн зоригтон”</p> <p>-Л.Болормаа “Америкийн индианчууд”</p>

<p>11.16. Зохиогчийн дүгнэлт, баталгаа нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж дүгнэх</p>	<p>Зохиогчийн гаргасан баталгаа нотолгоонд дүн шинжилгээ хийх</p> <ul style="list-style-type: none"> - Эхийг цогцолбор, эхийн агуулгын бүрдэл хэсгүүдэд хуваах - Өгүүлэгч дэвшүүлсэн асуудлаа батлахын тулд ашигласан баримт нотолгоонд ажиглалт хийх - Баримт нотолгоог зохиогч ямар зорилгоор ашигласныг эхийн утга санаа, дэвшүүлсэн асуудалтай холбож тайлбарлах <p>Зохиогчийн гаргасан дүгнэлтэд дүн шинжилгээ хийх</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн сэдэв – агуулга – гол санаа – дүгнэлтийн уялдаа холбоог тодорхойлох - Эхийн дүгнэлт хийсэн аргыг судалж унших, дүгнэлт хэсгийг ялгах тайлбарлах - Зохиогчийн дүгнэлтийг өөрийн үзэл бодолтойгоо харьцуулах <p>Зөвлөмж <i>Эрдэм шинжилгээний эхийн хувьд баримт нотолгоонд суурилсан дүгнэлт чухал байдаг бол чөлөөт сэтгэлгээний эргэцүүлэл бүхий эсээнд зохиогчоос бодрол, бясалгалын шинжтэй дүгнэлт давамгайлах тул тэдгээрийн үгийн санг судалж унших нь энэ чадварыг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй. Зохиогчийн авсан баримт эхийн сэдвээс шалтгаалан ялгаатай байж болно. Тухайлбал: Албан бус чөлөөт бичлэгийн хэв маяг давамгайлсан эсээнд зохиогчийн хувийн мэдлэг туршлагаас үүдэлтэй нотолгоог ашигласан нь түгээмэл байдаг. Эргэцүүлсэн эсээнд ашигласан тоо баримт бол баталгаа нотолгооны хамгийн чухал хэрэглүүр болдог. Гэхдээ ямар тоо баримтыг, зохиогч ямар зорилгоор ашигласныг эхийн утга санаа, дэвшүүлсэн асуудалтай холбож тайлбарлах нь илүү үр дүнтэй болно.</i></p>	<p>Эрдэм шинжилгээний эргэцүүлэл, эсээ</p> <p>Л.Түдэв “Монгол толбо” “Ирээдүйн өлсгөлөн” эсээ Ч.Галсан “Өв” эсээ</p>
<p>11.1в. Уран дүрслэл, хэлц, нэр томьёо, мэргэжлийн үг хэллэгийг хэрэглэсэн зорилгыг тодруулж, утга, үүргийг тайлбарлах</p>	<p>Уран дүрслэлийн утга, үүргийг тайлбарлах</p> <p>А. Үндэстний онцлогтой холбон тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхээс уран дүрслэл бүхий үг, хэллэгийг олж тэмдэглэх - Дүрслэл нь хэнийг? юуг? (дүр, төрх байдал, зан чанар... үйлдэл) уран дүрслэлийн ямар аргаар дүрсэлснийг хүснэгтлэх, бүлэглэх, зураглах, тодруулах зэргээр ажиглаж, дүгнэлт гаргахад хялбар болгож ажиллах - Дүрслэлийн учрыг тайлбарлахдаа монгол ахуй, соёлын онцлогтой холбон тайлбарлах - Уран дүрслэлийг хэрхэн бүтээдэг, уран дүрслэлийн утга үүрэг, түүнийг хэрхэн тайлбарлах талаарх ойлголтоо дүгнэх <p>Б. Зохиогчийн зорилго, өнгө аястай холбон тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - А-д ялгасан уран дүрслэлүүдээ ажиглах 	<p>Б.Пүрэв-Очир нар “Монгол хэл 11” сурах бичиг, Улаанбаатар, 2006, 45-53-р т.</p> <p>М.Базаррагчаа, “Монгол хэл 8” сурах бичиг, Улаанбаатар, 1999, 7-34-р т.</p> <p>Д. Баттогтох “Баримт уран сайхны 100 эсээ”</p>

	<ul style="list-style-type: none"> - Бичигчийн хэрэглэсэн уран дүрслэлүүдийг утга, ур маяг бүрээр нь нэгтгэж харвал ямар өнгө аяс, үзэл хандлага илэрч байгааг дүгнэх - Энэ өнгө аяс, хандлага нь зохиолчийн зорилготой хэрхэн уялдаж байгааг батлан тайлбарлах - Байгалийн зураглал, юмсын дүрслэл, орчны / орон ба цаг / дүрслэлийг ялгах, ажиглах - Зохиогчийн зорилго, хандлага, сэтгэлийн өнгө аясыг хэрхэн тодруулж байгааг шинжлэх - Орчны болон байгаль юмсын дүрслэлийг хэрэглэсэн зорилгыг тайлбарлах - Уран дүрслэлийг бичих зорилго, өнгө аястаа тохируулж сонгоно гэдгийг дүгнэж ярилцах, товч тайлбар дүгнэлт бичих <p>Хэлцийн утга, үүргийг тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Хэлцийн үүсгэл ба гол санаа, уран дүрслэлийг үндэстний онцлогтой холбон тайлбарлах - Хэлцийг хэрэглэсэн бичигчийн зорилго, хандлага өнгө аястай холбон тайлбарлах - Хэлцийг хэрэглэснээр тухайн эхийн утгад хэрхэн нөлөөлснийг дүгнэх <p>Эхэд хэрэглэсэн нэр томьёо, мэргэжлийн үг хэллэгийг тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхээс нэр томьёо ба мэргэжлийн үг хэллэгийг таньж ялгах - Найруулгад ямар зорилгоор хэрэглэснийг тайлбарлах - Нэр томьёо ба мэргэжлийн үг хэллэгийн ялгааг харьцуулан шинжлэх <p>Зөвлөмж</p> <p><i>Хэлц болон уран дүрслэлийн хэрэглээнд илүү анхаарах шаардлагатай. Ингэхдээ монгол үндэсний ахуй соёл, зан заншил, аж ахуй, уламжлал зэрэгтэй холбон, дасгал даалгавруудыг гүйцэтгэвэл сайн. Учир нь хэлц нь хэлний дархлаа болох төдийгүй хэл найруулгын эрдэнийн шигтгээ болж байдаг ажээ. Эдгээрийг ажилласны дараа хэлц болон уран дүрслэлийн талаарх ойлголтыг нэгтгэн дүгнүүлж, товч тайлбар бичүүлэх хэрэгтэй. Ялангуяа хэлцийн утгыг тайлбарлан бичиж сурахад анхаарах нь зүй. Учир нь энэ үйл ажиллагааг хийснээр монгол ахуй соёлын талаарх мэдлэг тэлэх, юмсын хоорондын учир холбогдлыг судалж, юмсын холбоо хамаарлыг тогтоох, дүгнэлт гаргах зэрэг чадварууд хөгжих сайн талтай.</i></p> <p><i>Товч тайлбар, дүгнэлт бичүүлэхдээ эдгээрийг ашиглаж болно. Уг тайлбар дүгнэлтийг дараах өгөгдлийн дагуу бичүүлж болох юм.</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Уншсан эх юуны тухай эсвэл эхэд ямар асуудлыг дэвшүүлсэн байна?</i> • <i>Уг асуудлын талаар бичихийн тулд ямар зорилгоор ямар ямар ойлголт, ухагдахуун нэр томьёог хэрэглэн ямар санааг баталж, нотлон бичсэн байна. Энэ нь уншигчдад хэр ойлгомжтой болсон байна.</i> • <i>Мэргэжлийн үг болон нэр томьёог ямар зорилгоор хэрэглэвэл үр дүнтэй байх талаар</i> 	
--	--	--

	<p><i>хэрхэн дүгнэв? Энэ талаар хэрхэн ойлгов? гэх мэт</i></p> <p><i>Түүнчлэн энэ товч тайлбарыг бичүүлэхдээ нэр томъёо ба мэргэжлийн үг хэллэгийн талаар харьцуулсан тайлбар бичүүлж болно. Ингэхдээ харьцуулах, жиших утгатай холбох хэрэглүүрийг хэрэглэхийг сануулаарай.</i></p>	
--	--	--

<p>11.1г. Орон, цаг, зорилго, шалтгааны утгыг эхийн жишээгээр харьцуулан, тайлбарлах</p>	<p>Эхийн орон, цаг, зорилго, шалтгааны утгыг тайлбарлах <u>Орон цаг :</u> Аян замын тэмдэглэл, шинжлэх ухааны хялбаршуулсан эхийг уншиж судлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн цаг хийгээд орны талаарх мэдээллийг ялгаж унших - Тухайн газар орон, цаг үеийн талаар үзэл бодлоо илэрхийлэх - Үйл явдал өрнөж буй орон цагийн шууд мэдээллээс гадна гол дүрийн амьдарч буй цаг үеийн талаар өөрт чинь шууд бусаар мэдрэгдэж буй зүйлсийг төсөөлөн ярих, өөрөөр хэлбэл, эхэд туссан цаг орны талаар ярилцах - Орон, цагийг дүрслэхэд ямар үгсээр түлхүүр хийснийг тайлбарлах (орон, цагийн нэр бүхий үгс) - Хүн, юм, үзэгдэл, үйл явдлыг хэрхэн сонирхолтой дүрсэлсэн - Үйл явдлын орон зай цаг хугацааны дарааллыг тайлбарлах, уялдаа холбоог гаргах - Уншигчийн сонирхлыг татахдаа зохиогч орчин нөхцөл, цаг хугацаа, эд юм, үзэгдэл, үйл явдлыг хэрхэн сонирхолтойгоор, учир зүйн холбоотойгоор сэтгэж, дүрсэлсэн болохыг холбон ярилцах <p><u>Зорилго, шалтгаан :</u> Зохиогч сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх, уншигчийн сонирхлыг татах, танин мэдүүлэх, түүх өгүүлэх, болсон үйл явдлыг мэдээлэх, итгүүлэх зэрэг зорилгоор бичдэг. Зорилгоос шалтгаалаад, уран дүрслэл, баймж утга, баримт нотолгоо, шинжлэх ухаанч тайлбар, үг хэллэг (далд санаатай, шилжсэн утгатай, мэргэжлийн, нэр томъёоны, албаны байх г.м) өөр өөр. Аян замын тэмдэглэл, эргэцүүлсэн эсээ, хөрөг найруулал зэрэг дүр дүрслэл бүхий хүүрнэсэн, тайлбарласан, эргэцүүлсэн аль ч эхэд зорилгыг дараах асуултуудын хүрээнд тайлбарлан ярилцаж болно:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн хамгийн содон зүйл нь юу болох талаар ярилцах - Ямар сэтгэгдэл мэдрэмж төрүүлэв - Аль үеийн ямар уншигчдад зориулж бичсэн, үүнийг эхэд хэрэглэсэн үг хэллэгээр тайлбарлах - Дүрслэлийг ялгаж, үүргийг тодорхойлох - Зохиогчийн мэдрэмж сэтгэгдлийг илтгэх үг хэллэгийг тайлбарлах - Зохиогчийн зорилгыг тодорхойлсон тайлбар гаргах г.м. <p>Эхийн учир шалтгаан, түүний үр дагаврыг үндэслэлтэй, нотолгоотой баримтуудаар нарийн уялдаа холбоотой тайлбарлаж сурах нь хүүхдийн хандлага төлөвшилд чухал нөлөөтэй бөгөөд дараах асуултуудын хүрээнд тайлбарлан ярилцаж болно:</p> <ul style="list-style-type: none"> - Асуудлыг тогтоох - Асуудлыг зөв дэвшүүлсэн эсэх. Хэрвээ дэвшүүлсэн асуудал оновчгүй бол гаргалгаа хийх боломжгүй болно 	
---	---	--

- Шалтгаан болон үр дагаврыг гаргах, ялгах
- Шалтгаан, үр дагаврын холбоог загвараар, схемээр гаргах
- Баримтууд үндэслэлтэй эсэхэд анализ хийх г.м.

Зөвлөмж

Эхийн шалтгааны утгыг тайлбарлана гэдэг учир хамааралтай олон асуудлыг тунгаан бодох, нэг зүйлийг олон талаас нь эргэцүүлэн бодох үйлтэй ихээхэн холбоотой. Энэ нь хүүхдэд асуудлын голыг олж харах, асуудлын шалтгааныг тогтоох, үр дүнг зөв тооцож сурахад сайнаар нөлөөлнө. Амьдралд тохиолдох элдэв үйл явдлыг хүүрнэн өгүүлсэн уран зохиолоос шалтгааныг, түүнээс үүдсэн эцсийн тайллыг эрэлхийлж шимтэн уншиж болох юм. Гэхдээ эрдэм шинжилгээний хялбаршуулсан бүтээл, эргэцүүлсэн эсээ зэрэг эхээс шалтгаан, түүний үр дүнг холбон гаргаж асуудлыг олж тайлбарлах нь хүүрнэн өгүүлсэн эхээс олж тогтоохоос ялгаатай юм. Тухайлбал, “...Сүүлийн үед <<Sugar free gum>> буюу саахар агуулаагүй бохь их моодонд орж байна. Энэ нь хүний эрүүл мэндтэй холбоотойгоор, бараг эмч нарын шахалтаар буй болсон эд. Учир нь саахараас ялгарах нүүрс ус мариалаг хүмүүсийн таргыг тэтгэгч болохоор тэр аж. Тэгээд ч саахар нь хүний амны хүчил шүлтийн харьцааг эвдэж, бичил биетүүд үржих таатай орчныг бүрдүүлж, шүд хорхойтуулдаг гэмтэй учир бохины найрлагаас хөөгдөж яваа юм. Ингээд саахарын оронд сорбит, маннитол, асфарт болон сакирин хэмээх чихэрлэг химийн бодисууд ашигладаг болжээ...” хэмээсэн эхийн шалтгаан, үрийг холбоог загварчилбал



Ингэж “бохины найрлага дахь нүүрс –уснаас болж” ямар үр дагавар үүсдэг, эдгээр үр дагавар эргээд орц найрлагыг өөрчлөх шалтгаан нь болсон тухай үндэслэлтэй тайлбарласнаараа шалтгааны утгыг оновчтой гаргаж чадсан. Хэрвээ “*Бохины найрлага дахь нүүрс –ус нь орц найрлагыг өөрчлөх шалтгаан болсон*” гэвэл шалтгаан, үр дагаврын тухай хөндөж болох ч үндэслэлтэй тайлбар болж чадахгүй байлаа. Өөрөөр хэлбэл, шалтгаан, үрийн харьцаагаар асуудлыг тайлбарлах нь хэр зэрэг нотолгоотой баримтад тулгуурласнаас шалтгаална. Мөн олон шалтгаанаас үр дүнг гаргасан бол нэлээд ул суурьтай, судалгаатай, олон талаас эргэцүүлэн бодож, шийдсэн болохыг илтгэнэ.

Түүнчлэн “Оюунтүлхүүр”, “Авах гээхийн дөрвөн мөрт”, “Тоть шувууны сургаал” г.м Монголын сургаалын шүлэг яруу найраг нь хүний амьдралын зөв буруу, болох болохгүйн учир шалтгааныг хэдхэн мөрд, тодорхой дүрсэлдгээрээ онцгой юм. Жишээлбэл:

“Үхэхийн урьд амьд цагтаа буяныг үйлд

Өтлөхийн урьд залуу цагтаа эрдмийг хичээ

Өвчин хүртэхийн урьд эрүүлдээ буян номыг хичээ

Үгүйрэхийн урьд баян цагтаа өглөгийг өг

Бүтэхийн дөрвөн нөхөр тэр болой...” гэж “Оюунтүлхүүр” сургаалд сайн сайхан амьдрахуйн үндэс шалтгаан, түүний үр дагаврыг ийнхүү товч тодорхой дүрсэлсэн байдаг.

Орон, цагийн утгыг шүлэг яруу найраг, өгүүллэг зэрэг уран зохиолын, намтар, хөрөг найруулал, аян замын тэмдэглэл, өдрийн тэмдэглэл, дурсамж, түүнчлэн шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол зэрэг дүрслэн бичсэн эх дээр задалж тайлбарлавал оновчтой болох. Ийм хүүрнэсэн, дүрсэлсэн, дүрслэн тайлбарласан эхэд хүн, юм, үзэгдэл, үйл явдлыг цаг хугацаа, орон зай, түүхэн он цаг, газар оронд илүүтэйгээр өрнүүлэн хүүрнэн өгүүлсэн байдаг. Зохиогч үйл явдал, орчин нөхцөл, цаг хугацааг хэрхэн сонирхолтойгоор, учир зүйн холбоотойгоор сэтгэж, уншигчийг догдлуулж биед мэдрэгдтэл, нүдэнд харагдтал дүрсэлж бичсэнээс судлан суралцах нь хүүхэд шинийг эрж, өөрийнхөөрөө сэтгэдэг болгоход туслах юм.

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа:	Хэрэглэгдэхүүн
<p>11.2а. Тодорхой асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэн бичих</p>	<p>Эргэцүүлсэн эсээ бичих</p> <ul style="list-style-type: none"> - Сэдэв ба асуудал тодорхойлох - Бичих асуудал болон түүнийг дэмжсэн нэмэлт санаануудаа тодорхойлох, зураглах - Гол асуудал болон нэмэлт санаатай холбоотой материал цуглуулах, судлах - Бичих төлөвлөгөө гаргах - Асуудлыг баримтуудаар нотолж батлах - Баримтыг өөрийн үзэл бодол, сэтгэгдэлтэй холбон тайлбарлах - Дүгнэлт хийх <p>Асуудлыг эргэцүүлэн бичихдээ дараах үйл ажиллагааны хувилбараас сонгон ажиллах</p> <ul style="list-style-type: none"> - Нэг асуудлыг 2 талаас /ерэг ба сөрөг, сул ба давуу/ бичих - Тухайн газар /улс орон, хот суурин, сургууль ... гм/ -т буй онцгой асуудлыг хөндөж бичих - Асуудлыг олон талаас нь таамаглаж бичих - Нийгэмд тулгамдсан асуудлыг харуулсан зургийн өгүүлэмжээр эргэцүүлсэн эсээ бичих - Бусдын бичсэн асуудлаас ургуулан эргэцүүлсэн эсээ бичих - Уншсан эхээс ээдрээтэй, асуудал дагуулсан өгүүлбэрийг сонгон авч эргэцүүлсэн эсээ зохиох <p>Зөвлөмж</p> <p><i>Энэ чадварыг хөгжүүлэхийн тулд 10-р ангид эзэмшсэн хөрөг найрууллыг бичихдээ мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ баримтад тулгуурлан дүрслэн бичих гэсэн чадвартай холбож судална. Харин 11-р ангид мэдрэмж, сэтгэгдэлтэйгээ холбохоос гадна “өөрийнхөө үзэл бодолтой холбон тайлбарлах” гэж чадвар өргөжсөн бол эцсийн үр дүн нь 10-р ангид эдгээр деталиудыг ашиглан дүрслэн бичих чадвартай болсон байх ба 11-р ангид эргэцүүлэн бичих чадвартай болохоор хөтөлбөрт тусгасан байгаа.</i></p> <p><i>Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмж, үзэл бодлыг тухайн баримтад тулгуурлан илэрхийлнэ. Энэ үед суралцагчдыг баримтыг унших явцдаа өөртөө юу бодогдож, сэтгэгдэж, мэдрэгдэж байгаагаа сайн анзаарч уншихыг зөвлөөрэй. Хүүхдүүд заримдаа баримттай ямар ч холбоогүй сэтгэгдэл, үзэл бодол, мэдрэмжийг илэрхийлээд байдаг. Тиймээс үүнийг зөв ойлгуулахын тулд баримт, үзэл бодол, үнэлэмж, сэтгэгдэл, мэдрэмжийн алийг хэрэглэснийг уншуулах явцдаа сайн шинжлүүлэх хэрэгтэй. Хэрэв унших явцад нь задлал хийлгэж, нэгтгэн дүгнүүлж бичүүлбэл бичих үйлийг хөтлөхөд дөхөм болно. Жишээ нь:</i></p> <p><i>Х.Цэвлээгийн “Шинжээ сонжоо” эргэцүүлэлд “Өдөржин “зүгээр”-ийг хийж, цаг мөчийг залгиж суудаг өвгөн миний бие яруу найрагч, орчуулагч Аюурзанын эмхэтгэн хэвлүүлсэн 60 суутны тухай номын хуудсыг эргүүлэх зуур нүдэнд өртсөн нэгэн сонирхолтой өгүүлбэр ухааныг минь гижигдэж, бодлын жимээр хөтлөв. “Хорин насанд мэдрэмж хаанчилдаг, гучин насанд авьяас, дөчин насанд ухаан</i></p>	<p>Эргэцүүлсэн эсээ</p> <p>Шүүмж</p> <p>Таамагласан эсээ</p> <p>Аян замын тэмдэглэл</p>

хаанчилдаг” тухай өгүүлбэр л дээ.” гэж уг эргэцүүллийг бичих үүдэл санаагаа гаргажээ.

Цаашилбал “Залуу зандан насанд жолоо цулбуургүй орь хүслэнд умбаж, бүтээх туурвихын гал дөлөнд шатаж явдаг болохоор эхний хоёр зүйлд элдэв тайлбар илүүц юм. Харин “ ухааны хаанчлал” гэдэг нь чухам юусан билээ? Тэр яагаад тийм хожуу бүр амьдралын намар хаяанд бууж, насны наран үдэлсний дараа морилон ирдэг “хүнд сурталтан” юм бол оо?” хэмээн өөрийн эргэцүүлэл, мэдрэмжээ харуулсан байна.

Түүнчлэн “300 гаруй жилийн тэртээ алс холын Испани орны гүн ухаантан Бальтасар Граснан агсны амнаас унасан энэ үг нь “Дөч хүрсэн эр амьдрал даана, дөрөв хөрвөсөн ат ачаа даана.” гэх монгол ардын цэцэн үгтэй төвө зайгүй, төрсөн ах дүү мэт төстэй байгаа нь юу сан билээ?” хэмээн эргэцүүлэх асуудлаа ийнхүү дэвшүүлжээ.

Харин гол хэсэгтээ үүнийг баталж нотолжээ. Ингэхдээ “Нийтлэг талаас нь эргэцүүлэн бодвоос эрээн бараан зөрчилт амьдралын халуун тогоонд 40-өөд жил чанагдсаны эцэст л хүний оюун ухаан сая нэг “болц нь гүйцэж” сэтгэлийн хойморт хаанчлан суух алтан титэм өмсдөг ажээ.” хэмээн өөрийнхөө үзэл бодол, мэдрэмжээ илэрхийлжээ. Энд үзэл бодол, мэдрэмж хоёрын ялгааг мэдэх шаардлага гарч ирнэ. **Мэдрэмж нь** харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар бөгөөд зарим зүйлд хариу үйлдэл үзүүлэх, түүнийг таних, үнэлэх, ойлгох чадвар юм. Өөрөөр хэлбэл гадаад орчныг мэдрэлдээ хүлээн авах чанар юм.

Сэтгэгдэл нь бодож, сэтгэгдсэн юм буюу хүн, юм, үзэгдлийн талаар төрсөн бодол, санаа гэсэн бол **үнэлэмж нь** юмны зэрэг, чанар хирийг тогтоосон, дүгнэлтийн шинжтэй юм байна. **Үзэл бодол гэдэг** нь ямар нэг асуудлын талаарх хувь хүний байр суурь, шийдвэр юм. Үзэл бодлыг хүний итгэл үнэмшил, ойлголт, онцгой мэдрэмж, үнэлэмж зэргийн үр дүн гэж ойлгож болно. Жишээ нь: Дээрх өгүүлбэрт эрээн бараан зөрчилт амьдралын халуун тогоонд чанагдах хэмээн амьдралаас авсан мэдрэмжээ өгүүлээд, эцэст нь хүний оюун ухаан сая нэг “болц нь гүйцэж” сэтгэлийн хойморт хаанчлан суух алтан титэм өмсдөг ажээ.” хэмээн өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн ажээ.

Хүний дотоод сэтгэлийг сахилгажуулан журамлагч “хаан ухаан” оройхон шиг морилон ирдэг ёс жаяг ийм л байдаг аж. Эзэн Чингис хаан 45, Өгөөдэй 43, Гүюг 42, Мөнх 45, Хувилай 45 насандаа тус тус хаан сууж байсан нь санамсаргүй хэрэг яавч биш байж. Манай үндсэн хуулинд улсын ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх насны босгыг 45-аар тогтоосон нь түүхэн уламжлалаасаа гажаагүй хэрэг ажээ.” хэмээн үзэл бодлоо түүхэн болон өнөөгийн бодит баримтаар нотолсон байна.

Нэр дурдсан монголын нэгдсэн төр улсын таван их хааны үед л монголчууд дэлхийн “хаан улс” болж мандан бадарч явсан нь хаан ухааны ач тус байж болох” хэмээх таамаглалаар санаагаа батлаад “Ингэж л нас намба гэдэг хувь хүний төөрөг төдийгүй улс орны хувь тавилан болдог учиртай.” гэж үзэл бодлоо илэрхийлжээ.

Олонх улс оронд нас тогтсон егзөр толгойнууд засаг төрийн дээд суудлыг эзлэнхэн сууцаана. Хүн

	<p><i>төрөлхтний амьдралаар шалгагдсан бичигдээгүй хууль байдаг ажгуу.” хэмээн асуудлыг бусад орны хувьд нийтлэг байдаг “бичигдээгүй хуулиар” асуудлаа баталсан байна. Би бээр энэчлэн сэтгэхийн чацуу одоогийн УИХ, засгийн газрын бүрэлдэхүүнийг насны хэмжүүрээр нь сонжиж үзэх хүсэлд автав. Нийт бүрэлдэхүүний үнэмлэхүй олон нь “хаан ухаан” –аа залж авчрах насандаа хэдийнээ хүрч амжсан байлаа. Сонгогч түмэн сайхан хүсэл мөрөөдөлд итгэхээсээ илүү “хаан ухаан” –д итгэдэг болжээ.” хэмээн үзэл бодол, үнэлэмжээ харуулсан байна.</i></p> <p><i>... Эдгээр дүн тоймууд манай өнөөгийн төр, засгийн төв өндөрлөгт оюун ухааны хаанчлал бий болжээ” гэж хэлэх зүрх зориг надад хайрлав. Хүн хэдий чинээ насжина төдий чинээ жинхэнэ хүн болно гэж мэргэд айлдсан болохоор сэтгэл баахан уужирнам. Миний хэлэх гэсэн өнгөрсний шинжээ, өнөөдрийн сонжоо ийм.” хэмээн асуудлаа дүгнэсэн байна.” гэх мэтээр үйл ажиллагаануудаа нэгтгэн дүгнэж, тайлбар хийж болох юм. Ингэж хийж гүйцэтгэсэн задлан шинжлэх үйл ажиллагаануудаа нэгтгэн дүгнэж бичих нь эргэцүүлэн бичихэд хэрэг болно.</i></p> <p><i>Асуудлыг үзэл бодол, сэтгэгдэлтэйгээ холбон олон талаас нь эргэцүүлэн бичихдээ санал болгосон хувилбарт үйл ажиллагаануудаас сонгож хийнэ. Ингэхдээ асуудлыг эерэг сөрөг талаас баталж, нотлон асуудалд тэнцвэртэй хандах зарчмаар хийнэ. Жишээ нь: Дунд сургуульд дүрэмт хувцас өмсөх нь хэрэгтэй юу? Хэрэггүй юу? гэх мэт</i></p> <p><i>Эсвэл “Дунд сургуульд дүрэмт хувцас өмсөх нь зөв” гэсэн нэг асуудлыг олон талын жишээ баримтаар нотолж бичиж болно.</i></p> <p><i>Өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ шалтгааныг баримтаар тайлбарлаж сурахад анхаарах хэрэгтэй. Учир шалтгааныг хэрхэн тайлбарлах тухай 8, 9, 10-р ангид судалсан учраас энд дэлгэрүүлэн тайлбарласангүй.</i></p> <p><i>Сэтгэгдэл, үзэл бодлыг ялгаатай бичүүлэхийн тулд тухайн асуудал ба баримтын талаар тухай үед юу бодогдож, сэтгэгдэв? Гэх асуултаар сэтгэгдлийг, энэ баримт, асуудлын талаар юу гэж үздэг вэ? Эсвэл санал нийлдэг үү? үгүй юу? Зөв үү? Буруу юу? Хэр итгэл үнэмшилтэй байдаг вэ? Яагаад гэх мэтээр асуултын аргаар ялгуулж болох юм.</i></p>	
<p>11.26. Үйл явдлыг хүүрнэн бичихдээ орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх</p>	<p>Аян замын тэмдэглэл бичихийн өмнө санаагаа цэгцлэх</p> <ul style="list-style-type: none"> - Аялсан газруудаас санаанд чинь хамгийн тод бууж байгаа нь аль нь байна вэ? - Алиных нь тухай хамгийн их боддог вэ? - Хүмүүсийг гайхшруулсан, юм үзэгдэл, үйл явдал юу байв? - Чамд таатай, таагүй санагдсан үйл явдлууд юу байв? - Чиний ирээдүйд ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлсэн, өөрчилсөн үйл явдал юу байв? - Чухам алийг нь уншигчдад хамгийн сонирхолтой бичиж чадах вэ? - Уншигчдыг үйл явдалд оролцсон юм шиг мэдрэмж төрүүлэхээр хэрхэн бичих вэ? <p>Аяллынхаа сонин сайхныг дүрслэн хүүрнэж бичих</p> <ul style="list-style-type: none"> - Хэзээ?, хаана?, яагаад?, (ямар учраас, юунаас болж) хэн? юуг? яав? гэсэн асуултад хариулж бичих) 	

Цогцолборуудыг болон үйл явдал түүний юунаас болж цааш өрнөж байгаа шалтгаануудыг сонирхолтойгоор, логик учир зүйгээр, оновчтой холбох

- холбох үгээр (эхлээд, дараа...)
- холбох нөхцөлөөр (ж,ч, саар⁴ ...)
- цаг хугацааны утгатай үг (удахгүй...)

Аялсан газар орноо дүрслэх

- Үйл явдал хаана өрнөсөн, (хаагуур аялсан)
- Бодит тодорхой газар оронд уу?, эсвэл ерөнхий газар оронд уу?
- Аялсан газар орны байр байдал, өнгө зүс, тоо хэмжээ, гэрэл сүүдэр зэргийг нүдэнд үзэгдтэл дүрслэх

Аялсан цаг хугацаагаа дүрслэх

- Үйл явдал хэзээ болсон, (хэзээ аялсан) бодит тодорхой түүхэн цагт уу?, эсвэл ерөнхий цагт уу?
- Монголчууд цаг хугацааг улирал, хүний насны мөчлөг, малынхаа ааш аяг, сарны хөдөлгөөн, тооноор тусах нарны тусгал зэргээр баримжаалдаг уламжлалтайг санах

Аялсан газар орны нөхцөл байдлаа бичих

- Аялсан газрын цаг улирал, уур амьсгал, нутаг орны байр байдал, хүрээлэн буй юмс үзэгдэл, орчны эд юмс, түүний байр байдал, өнгө зүс, тоо хэмжээ болон гэрэл сүүдэр, үндэстний соёлын онцлог, нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, тэдгээрийн харьцуулалт, энэ нь чамд ямар сэтгэгдэл мэдрэмж төрүүлсэн, аялалд яаж нөлөөлж байв...
- Нөхцөл байдлыг үзүүлэхдээ ямар онцлог үг ашиглах, улам тодотгохын тулд ямар ур маяг хэрэглэх

Аяллаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх

- Аяллаар явахад ямар мэдрэмж төрөв?
- Чиний анхны сэтгэгдэл ямар байсан бэ?
- Аяллын аль хэсэг хамгийн гайхамшигтай эсвэл сонирхолгүй байсан бэ?
- Аль нутаг орон хамгийн тод санагдаж үлдэв?
- Хамгийн их сэтгэл дэнслүүлсэн үйл явдал юу байв?
- Энэ үйл явдлыг зургаар илэрхийлвэл ямар өнгө будаг хэрэгтэй вэ? гэх мэт
- Мэдрэхүйн таван эрхтнээр дамжиж юу мэдрэгдсэн, (харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх), ямар санагдсан, юу бодогдсон, юу ухаарсан)

Бичих төлөвлөгөө гаргах

- Бичих бүтэц болон дарааллаа сонгох
- Эхийн хэсгүүдийг уншигчдын сонирхлыг татан дагуулах учир зүйн дараалалд оруулж зохион байгуулах (Энгийн зохион байгуулалт нь эхнээс нь төгсгөлд чиглэсэн байдаг бол цаг хугацааны дарааллаар, эсвэл онцгой нэгэн үйл явдлаас эхэлсэн байж болно)

Бичсэнээ ноороглох

- Төлөвлөсөн бүх хэсгээ ноорогтоо багтаахыг хичээх
- Уншигчдад сэтгэгдэл төрүүлэхийн тулд дүрслэл сайн ашиглах

Бичсэнээ хянах

- Хэзээ?, хаана?, яагаад?, (ямар учраас, юунаас болж) хэн? юуг? яав?
- Үйл явдлын орон, цаг, нөхцөл байдлыг тодорхой дүрсэлсэн үү?

	<p>- Үйл явдлын орон, цаг, нөхцөл байдлыг үзүүлэхдээ дүрслэл ашигласан уу?</p> <p>- Учир зүйн дарааллаар зөв, сонирхолтой холбосон уу?</p> <p>- Гайхалтай, дурсамжтай хэсгүүд байна уу?</p> <p>- Бичлэг нь бүхий л таван мэдрэхүйд мэдрэгдэхээр байна уу?</p> <p>- Мэдрэмж, сэтгэгдлээ тодорхой дүрслэн илэрхийлсэн үү?</p> <p>Бичсэнээ засах</p> <p>- Бичсэнээ тайван хянамгай батлан унших</p> <p>- Зөв бичих зүйн болон найруулгын алдааг засах</p> <p>Зөвлөмж</p> <p><i>Баримтын эхийг үйл явдлын зангилаа, өрнөл, туйл, тайлал гэсэн уран сайхны эхийн өгүүлэгдэхүүний дарааллын дагуу бичих шаардлагагүй. Харин үйл явдлыг сонирхолтойгоор өрнүүлэх, тодруулбал өөрт тохиолдсон үйл явдлыг баримтад үндэслэн сонирхолтойгоор өрнүүлэн бичих юм. Ер нь сонссон, уншсан хүнд дүр зураг буутал бичнэ гэдэг хүүрнэмж эхийг бичих хамгийн чухал алхам юм.</i></p> <p><i>Үйл явдлыг өрнүүлэхдээ:</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Хэзээ?, хаана?, яагаад?, (ямар учраас, юунаас болж) хэн? юуг? яав? асуулт</i> • <i>Үйл явдлын эхлэл, гол, төгсгөл</i> • <i>Бүтэц тус бүрийн дүрслэлийн ялгаа (эхлэл: танилцуулга, гол хэсэг: үйл явдлын өрнөл, төгсгөл: дүгнэлт)</i> • <i>Үйл явдлын хувирал өөрчлөлт</i> • <i>Үйл явдал ба цогцолборуудыг сонирхолтойгоор, логик учир зүйгээр, оновчтой холбох арга (холбох үг, нөхцөл, цаг хугацааны утгат үг)</i> • <i>Үйл явдлыг нүдэнд харагдтал дүрслэх, төсөөлөх хэрэгсэл (өнгөрсөн цагийн утгат үйл үг)</i> • <i>Үйл явдал юунаас болж цааш өрнөж байгаа шалтгаанууд</i> • <i>“Бүхнийг ил хэлэхгүй орхих” арга</i> <p><i>Сонирхолтой харилцан яриа зэргийг илэрхийлэн бичнэ.</i></p>	
<p>11.2в. Эшлэл, ном зүй, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загвар зэргийг ашиглан бичих</p>	<p>Бичихдээ эшлэл, зүүлт, ном зүй ашиглах</p> <ul style="list-style-type: none"> - Эшлэл, номзүй, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загварын талаарх ойлголтоо нэгтгэх - Эшлэл, ном зүй, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загвар зэргийг ашиглан бичихийн тулд багшийн бэлтгэсэн өгөгдлүүдийг ажиглаад сэдэв буюу ямар асуудал дэвшүүлж болохыг тунгаан бодох, хэлэлцэх - Эшлэл, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загвар зэргийг ашиглан дэвшүүлсэн асуудлаа тодорхой тогтолцоонд, учир шалтгааны уялдаа холбоотой, зөв дараалалтайгаар дэлгэрэнгүй тайлбарлан бичих <p>Зөвлөмж</p> <p><i>Эшлэл, ном зүй, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загварын талаарх ойлголтоо нэгтгэхдээ дараах зүйлийг анхаарах нь зүйтэй.</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Эшлэл авахдаа зохиогчийн бичсэн байдлаар нь шууд хуулан авч хэрэглэх бөгөөд хашилтад бичнэ.</i> • <i>Эшлэлийг 1. эх дотор, 2. тухайн хуудасны доод хэсэгт (хөлд), 3. ном зүйн жагсаалтыг үндэслэн тэмдэглэнэ.</i> 	

	<ul style="list-style-type: none"> • Эшлэл авсан эх сурвалжийг хуудас бүрийн доор зүүлт тайлбар буюу footnote хэлбэрээр бичиж болно. Эшлэл авсан эх сурвалж дараалан яг давтагдсан тохиолдолд (мөн тэнд) гэж тэмдэглэнэ. • Зүүлт бичихдээ тодотгон оруулж буй тэмдэглэл нь нэг хуудсанд байх талаар анхаарна. Хэрвээ тэмдэглэл нь тухайн хуудсанд багтахгүй бол дараагийн хуудас руу шилжүүлж болно. • Эшлэл зүүлтэд орсон бүтээлийг тухайн ажлын хүрээнд нэгдсэн байдлаар төгсгөлд нь ном зүйд бүрэн тусгана. • Ном зүйг дүгнэлтийн ард хийнэ. <p>Эшлэл зэргийг ойлгомжтой болгох үүднээс хялбаршуулж юм уу, эсвэл учир явдлыг ухуулах зэргээр тайлбар хийж болно. Мөн эш татсан бүтээлийн тухай юм уу, эсвэл зохиолчийн тухай тайлбарыг эх дотор оруулж болохын зэрэгцээ цөөхөн тайлбарыг зүүлтээр оруулж болно.</p>	
<p>11.2г. Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих</p>	<p>Эхийг хураан бичихдээ анхаарах зүйл, хураах аргууд:</p> <ul style="list-style-type: none"> - Тулгуур үгсийг олж, санааг хураан бичих - Өгүүлбэрээр хураах - Хэлцээр хураах - Эхийн гол санааг тулгуур үгсийг ашиглан цөөн үгээр илэрхийлэн бичих <p>Эхийг дэлгэрүүлэн бичихдээ анхаарах зүйл, дэлгэрүүлэх аргууд:</p> <ul style="list-style-type: none"> - Эхийг санааг уншиж ойлгон, тулгуур үгийг үг, холбоо үг, өгүүлбэрээр нэмэн дэлгэрүүлэх - Эхийн гол санааг тайлбарлан дэлгэрүүлэх - Эхийн цөм өгүүлбэрт дэлгэрүүлэгч гишүүд нэмж санааг өргөжүүлэх - Эхийг адилтгал, зүйрлэл, хэлц зэргээр баяжуулах <p>Зөвлөмж Эхийг үгээр (гишүүнээр), өгүүлбэрээр дэлгэрүүлэх хоёр арга байдаг хэдий ч чухам юуг нь дэлгэрүүлэхээс арга нь хамаарна. Сурагчдыг дэлгэрүүлэх аргад сургахдаа юуг дэлгэрүүлэхийг эхлээд тодорхойлно.</p> <p>а. Эхээ дэлгэрүүлэх б. Хураасан бүтцээ дэлгэрүүлэх</p> <p>Эхээ дэлгэрүүлбэл орны, цагийн шинжийн гээд утгыг нь баяжуулж болно. Хураасан бүтцээ дэлгэрүүлбэл эхний өгсөн эхтэй ойролцоо утгатай эх, эсвэл эсрэг утгатай эх болгон дэлгэрүүлэн найруулж болно.</p>	<p>Төрөл бүрийн уран зохиолын болон уран зохиолын бус эхээс тохирохыг нь сонгон хэрэглэх</p>
<p>11.2д. Холбох хэрэглүүрээс сонгож, нийлмэл өгүүлбэрийг хувирган найруулах</p>	<p>-Утга санаанд тохируулан холбоос болон нөхцөлөөр зэрэгцүүлэн болон угсруулан холбож, нийлмэл өгүүлбэр бүтээлгэж, утгын ялгамжааг тайлбарлах</p> <p>- Хос хосоор өгүүлбэрүүд өгч ажиглалт хийлгэн, яаж хувиргасан байгааг тайлбарлуулах (өгүүлбэрийн өгүүлэхүүн нь нэр үг ба тэмдэг үгээр илэрсэн, үйл үгийн тусах эс тусах шинж, хэвийн нөхцөл давхарласан зэргээс болж ямар өөрчлөлт орсон г.м)</p> <p>-Өгүүлбэрүүдийг тохирох холбоосоор холбох</p> <p>Жишээ нь: “Эмэгтэй зохиолч хуруу дарам цөөн байсан тэр цагт С.Удвал зохиолч нөхдөдөө өмөг түшиг нь, өгөөмөр сэтгэлтэй эх нь болж, тэднийхээ шинэ зохиолыг сонсох дуртай байсан.¹ Өөрөө уран зохиолын олон төрлөөр туурвиж, яруу найргийн төрлөөр авьяасаа сорьж, хэд хэдэн</p>	

нямбай шүлэг бичсэн билээ.² “–2 өгүүлбэрийг холбоход “иймээс, харин, тэгвэл, түүнчлэн” г.м холбоосуудын аль тохирохыг ярилцаж, утгыг тайлбарлах
 “Та нарыг хичээлээс хоцорсон гэж дуулсан”
 “Та нарыг хичээлээс хоцорсон гэж зэмлэсэн” –зэрэг бүтэц хэлбэр ойролцоо боловч илэрхийлэх утга өөр өөр өгүүлбэрүүд дээр ажиглуулан тайлбарлах. Үүний 2 дахь өгүүлбэрт шалтгаан –үрийн харьцаа илэрч байгаа.

Саахар нь хүний амны хүчил шүлтийн харьцааг эвдэж, бичил биетүүд үржих таатай орчныг бүрдүүлж, шүд хорхойтуулдаг гэмтэй	учир учраас тул -гээс болсон- Д болохло ор	бохинь найрла аас хөөгдө яваа юм.
---	---	--

гэх мэтээр өгч ажиглуулан, утгын ялгаа гарч буй эсэх талаар ярилцаж, утгын ялгаагүй, сольж холбож болохыг, “Тэнгэр цэлмэг байв. Гэтэл үүл гарав.” гэхийг “Тэнгэр цэлмэг байтал үүл гарав” гэж холбож болох ба “гэтэл” гэсэн холбоос нь уг өгүүлбэрээ өмнөх өгүүлбэртэй эсрэгцүүлэн холбох утгатай г.м-ээр тайлбарлах.

Лувсангийн ууц нуруу бадайрдаг	бол байхад харин тэгвэл ба	миний ууц нуруу шархирдаг юм. (Ц,Д)
--------------------------------	--	--

гэх мэтээр өгч, утгын ялгаа гарч буй эсэхийг ярилцах. Эхний 3-н холбоос (бол, байхад, харин) нь харьцуулан жиших утга зааж байгаа бол “тэгвэл” гэсэн холбоос нь эсрэгцүүлэн зэрэгцүүлэх, “ба” холбоос нь зэрэгцүүлэх утгыг тус тус илтгэж байна.

Зөвлөмж

Нийлмэл өгүүлбэр тус бүрийн өгүүлэхүүн төвийг тогтоож, нөгөө өгүүлбэртэй нь зэрэгцүүлсэн, нэгийг нөгөөд захируулсан холбох хэрэглүүрийн аль нь болохыг ажиглуулан тайлбарлана. Ингэхдээ нийлмэл өгүүлбэрийн зэрэгцсэн, угсарсан утгыг ялгаруулж буй холбох хэрэглүүрийг тодорхойлуулна. Тухайлбал, “хэрэв... бол” холбоос нь “хэрэв...” гэдэг талаас нь үзвэл гадаад холбоосын шинжтэй, “...бол” гэдэг нөхцөлдүүлэх хэлбэрийнхээ талаас дотоод холбоосын шинжтэй. Монгол хэлний хөгжлийн явцад “хэрэв ...бол” хоёр нь нэг нь нөгөөгөө шүтэлцэж, нэгэн цогц холбох хэрэглүүр болж, улмаар урагшаа хойшоо нөхцөлдүүлэх, шалтгааны утгатай болжээ. Жишээ нь: Хэрэв чи замдаа тохиолдох боорон хуцагч ноход болгон руу чулуу шүүрэх юм бол хэзээ ч зорьсон газартаа хүрч чадахгүй. (Ф.Д), Хэрэв тэнгэр хүний санаагаар загнах юм бол хэдүй нь энэ ертөнц сөнөх биз.(Р.Ч), Хэрвээ Сумьяагийн 26 зангиа, зун өвлийн 6 малгайны өнгө зүс, янз маяг, ямар үед, яаж өмсдөгийг бичих юм бол цаг, цаас их орно.(Л.В), Хэрэв би морьтой болоод завтай сан бол...(Д.Н) г.м. нийлмэл өгүүлбэрийн түвшинд харвал “хэрэв ...бол” гэдэг холбоос нь болзол

	<p>шалтгааны утгатай байц гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэртэй нь захируулах харьцаагаар холбодог. Тэвэл дан "...бол" гэсэн холбоосоор холбоход утгын тодорхой ялгаа гарахгүй (жишээ нь: Машин суугаагүй бол энэ хүний намтрыг би мэдэхгүй л өнгөрөх байж дээ (Л.Ч) г.м.). бөгөөд "хэрэв ..." тэй холбох үед утгын өргөлт, чухалчлагдсан утга илрэх юм.</p> <p>Харьцуулан тайлбарлахад өгүүлбэрүүдийг "...-сэн⁴ бол, ...-сэн⁴ байхад, ...-сэн⁴, ...-хад⁴" г.м холбох үг, нөхцөлүүдээр цувуулан бичихээс гадна таслалаар ялган заагладаг бол танин мэдүүлэх зорилготой бичил эхэд шалтгаан –үр холбоог гаргахын тулд "яагаад гэвэл, учраас" гэсэн холбоосуудыг хэрэглэсэн байна.</p>	
--	---	--

11.2.3 ЯРИХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.3а. Тодорхой цаг хугацаа, орон зайд болсон хэрэг явдлыг дүрсэлж ярих</p>	<ul style="list-style-type: none"> - Дэвшүүлсэн асуудлуудаас сонгох - Судалгаа хийх - Холбоотой баримт нотолгоог цуглуулах, цэгцлэх - Төлөвлөгөө гаргах - Болж буй үйл явдал, болж буй орон, цагаа ажиглаж, төсөөлөх зэргээр сэтгэлд буутал дүрслэх - Өөрийн үзэл бодол, сэтгэгдэл мэдрэмж, эшлэл баримтыг хаана нь оруулахаа шийдэх - Аль цаг /өнгөрсөн, одоо, ирээдүй/-т болж буй үйл явдлын тухай ярих вэ? гэдгээ шийдэх - Эл үйл явдалд хэрхэн хандах, аль өнцгөөс нь харж ярихаа төлөвлөх - Дүгнэлт хийх <p>Зөвлөмж Энэ суралцахуйн зорилтыг эзэмшүүлэхдээ сурвалжилга хийх, дүрд тоглох замаар хичээлийг удирдан зохион байгуулбал илүү үр дүнтэй болно. Ингэхдээ нийтэд хамаатай чухал үйл явдал, үзэгдэлд өгүүлэгч өөрөө оролцож, түүний амьд гэрч болж, тухайн хэрэг явдлыг нүдэнд харагдаж, гарт баригдаж, аманд амтагдаж, чихэнд сонсогдож, хамарт үнэрттэл тийм барин тавин, сонсогчийн бүхий л мэдрэхүүд хүртээгдэхээр өгүүлнэ гэсэн үг. Гэхдээ асуудал нь эерэг сөрөг ямар ч байж болно.</p> <p>Хэрэв дүрд тоглуулах, сурвалжилга хийх замаар хичээлийг удирдах бол үүнийг бие даалтын цагаар өгч бас болно. Ингэхдээ багш тодорхой чиг гаргаж өгнө. Үлгэрлэвэл:</p> <ul style="list-style-type: none"> • Хэн, хаана, хэзээ, юуг, хэрхэн, яах гэж, мэдээлэх гэж байгаагаа сонгоно. 5W1H / who- хэн, where-хаана, when-хэзээ, what-юуг why- яах гэж, яагаад, how-хэрхэн/ арга нь гол мэдээллийг дамжуулах асуултын арга юм. Үүнд хариулагдахаар мэдээллийг бэлтгэвэл уншигч, сонсогчдод, ойлгомжтой тодорхой байдаг байна. • Тухайн газарт юу хамгийн асуудалтай байгааг олж мэднэ. Багаар ажиллуулах ба өөрсдөөр нь шийдвэр гаргуулж, асуудлыг сонгуулах хэрэгтэй. • Тухайн газар дахь асуудлыг баталж, нотлох баримтуудыг цуглуулна. Энэ үед багш олон янзын эх сурвалжийг хамарсан баримт нотолгоо цуглуулж ирэхийг шаардаж болно. Ингэхдээ хэвлэл мэдээллийн 	<p>Бодит амьдралтай холбоотой асуудлууд</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн орчин дахь • Гэр бүлийн орчин дахь • Найз нөхдийн хүрэн дэх гэх мэт <p>Бичлэг хийхэд шаардлагатай цахим хэрэгслүүд</p>

	<p>хэрэгслээр яригдаж байгаа яриа, сурвалжлагуудыг хайж олох, цахим ертөнц, сонин сэтгүүл, бусад мэдээллийн эх үүсвэрээс холбоотой мэдээг олж болно. Мөн хаана очиж хэнтэй уулзаж ярилцах вэ? Тэр хүнтэй ярилцахдаа ямар газрыг сонгож зураг авах вэ? Ямар асуулт асуух юу? Юуе шууд мэдээлэх вэ? гэх мэтээр бүх зүйлийг урьдаас бодож, төлөвлөсөн байдлаар бүтээлчээр ажиллуулж болно. Мөн оршин суугчдаас тодорхой асуулт бэлтгэж, түүнийхээ дагуу судалгаа авч, нэгтгэн, үр дүнг шууд мэдээлэх зэргээр бүтээлч байдлаар хүүхдүүдийн оролцоог хангаж, хичээлийг удирдаж болно. Гэхдээ болж өгвөл сурагчдад өөрсдийнх нь орчинд тулгардаг, өөрсдийнх нь амьдралтай ойр тийм асуудлуудаас сонговол маш сайн.</p> <ul style="list-style-type: none"> • Олсон баримтуудаа цэгцлэхдээ: Тухайн сонгосон асуудлыг маш сайн баталж нотолж чадах уу? Сэтгэгдэл, тайлбар хийх боломжтой юу? Сонсогчийн сэтгэлд буутал мэдээлэхэд хангалттай юу? Сонсогчийн анхаарал, сонирхлыг татах уу? гэх мэтээр шалгуур таавьж сонговол сайн. Учир нь дүрслэн мэдээлнэ гэдэг бол уншигч, сонсогчийг тухайн газар очиж үзэхийг хүстэл, эсвэл тухайн газар очоод үзсэн юм шиг тийм мэдрэмжийг өгөх ёстой. <p>Тодорхой цаг хугацаа, орон зайд болсон хэрэг явдлыг дүрслэн мэдээлж ярихад чиглэсэн үйл ажиллагааны үед үгийн сонголт, дүрслэл хоёрт маш их анхаарвал зохино.</p> <p>Үлгэрлэбэл:</p> <ul style="list-style-type: none"> ○ Маш тодорхой, тухайн хэрэг явдлыг сонсогч өөрөө үзэж харж буй мэтээр тод томруун дүрсэлнэ. Энэ чадвар нь 10-р ангид эзэмшсэн хүн ба юмсын гадаад дотоод шинжийг хөрөглөх чадвартай шууд холбогдоно. ○ Үйл үгийг ерөнхий биш тодорхой үйл хөдөлгөөн, дүр байдал, дуу чимээ заасан утгаар нь хэрэглэвэл илүү сайн дүрслэл болно. ○ Тэмдэг нэр, тодотгол гишүүн өгүүлбэр, орон цагийн нэр, авиа дуурайх үгийг тов тодорхой утгаар нь хэрэглэнэ. ○ Цаг хугацаа заасан үг, хэллэг, хэлзүйн хэрэглүүрийг оновчтой хэрэглэнэ. ○ Мэдээлэх болон хүүрнэх хэлбэрийг хослуулбал илүү сонирхолтой, ойлгомжтой байх болно. ○ Үнэлэлт дүгнэлт өгч байгаа мэтээр ерөнхий утгат тэмдэг нэрийг хэрэглэхээс зайлсхийж хүний мэдрэхүйд өртөхөөр тийм дүрслэл, үг хэллэгийг сонгож аваарай. Муухай үнэртэй гэхээс илүү муудсан тосны эхүүн үнэр гэвэл илүү тодорхой болно. ○ Мэдрэмжээ мэдрэгдэхээр тодорхой дүрсэлнэ. 	
--	--	--

ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.4а. Холбох хэрэглүүрийн утга, үүргийг тодорхойлж, нийлмэл өгүүлбэрт сонгон найруулах</p>	<p>- Уншиж судалж буй эхийн нийлмэл өгүүлбэрүүд дээр жишээ авч гишүүдээр ялган ажиллуулан, холбох хэрэглүүрийн утга үүргийг доорх байдлаар тайлбарлаж тодорхойлох</p> <p>“Хэрэв чоно тусалбал хэдгэнэ ч морь унагана.” гэхэд чоно тусална, хэдгэнэ морь унагана гэсэн хоёр өгүүлбэрийг шалтгаан –үрийн утга үүрэгтэй холбоосоор холбожээ.</p> <p>“Хэдэн айлаар орж, мал хүлээн авах бэлтгэлийг шалгаж зааварлах даалгаврыг багийн даргаас авсан юм. Тэгээд мордох санаатай байна. –Тэгвэл чи өглөөний мордохгүй яасан хүн бэ?” гэхэд зэрэгцэх нөхцөл ба тэг үндсээр холбосноос гадна өмнөх өгүүлбэрийн агуулгыг бүхэлд нь багтаасан “тэгээд”, эсрэгцүүлсэн утгатай “тэгвэл” гэсэн төлөөний үгээр холбожээ.</p> <p>“Тамгын газраар оролгүй, уран аргаар нутаг бэлчээрээ эргүүлж авсан минь таатай Ø хэрэг биш үү. (Б.Р)” гэхэд “-лгүй” гэсэн үгүйсгэх нөхцөлөөр, “авсан Ø” гэсэн нэрлэхийн тийн ялгалаар, “таатай” гэж үндсээр холбосон. г.м.</p> <p>1.“Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг. Малчин баян бол улс баян. Хэрвээ бид хийхгүй юм бол хэн хийх вэ. 2.Хангай газрын алтан шар намар сайхан бол Тамирын хөндийн намар бүр ч үзэсгэлэнтэй.¹ Тус орны баруун хэсэгт мөнх цас, мөсөн голтой өндөр уулс сүндэрлэдэг бол зүүн хэсэгт нь тал газар үргэлжилдэг.² Ховд, Баянхонгорын өмнөд хэсгээр 8-15, бусад нутгаар 1-7 хэм хүрч дулаардаг бол хүйтэрсэн үед шөнөдөө Увс, Завхан, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Хэнтийн хойд хэсэг, Сэлэнгийн нутгаар 44-52 хэм хүйтэн болдог.”³ г.м өгүүлбэрүүдийг өгч, гишүүдээр ялган, хэчнээн өгүүлбэр юугаар яаж холбогдсон, ямар утга үүрэгтэйг тайлбарлах. Тухайлбал, 1-р хэсгийн НӨ-үүдийг гишүүдээр ялган ажиглахад “бол” гэсэн холбоос нь дараах шинжтэй байна. Үүнд: а. Нийлмэл өгүүлбэрийн хоёр хэсэг нь учир зүйн үүднээс шалтгаан –үрийн холбоотой байгаа б. Гишүүн өгүүлбэр +гол өгүүлбэр гэсэн хэлзүйн дэс дараатай байгаа в. Эхний өгүүлбэр нь дараагийн өгүүлбэртээ захирагдсан шинжтэй г. Эхний өгүүлбэр нь удаах өгүүлбэртээ шалтгааны байц гишүүн өгүүлбэрийн утга өгч байгаа д. Үйлийн тийн ялгалын болзохын “-бал⁴, -вал⁴” нөхцөлийн шинжтэй. “Малчин баян бол улс баян” гэсэн өгүүлбэртэй бүтэц, утгаараа ойролцоо “Малчин баян байвал улс баян байна”, “Малчин баян болбол улс баян болно” гэсэн маягийн өгүүлбэр бас зэрэгцэн хэрэглэгдэж байгаа бөгөөд “Малчин баян бол...” гэдгийн “-бол” нь “бай+вал”, “бол+бол” гэдгийн “бай-, бол-”-ын үүрэг нь суларч орхигдсоноос үүссэн хэрэглүүр юм. 2-р хэсгийн НӨ-үүдийн “бол” холбоосыг ажиглахад: а. өгүүлбэрийн хэсгүүдийн хооронд учирзүйн үүднээс нарийн нөхцөлдсөн шалтгаан –үрийн холбоо байхгүй б. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн хэв шинжтэй</p>	<p>Эргэцүүлсэн эсээ</p> <p>Уншиж судалж буй төрөл бүрийн эхүүд</p>

	<p>в. Өгүүлбэрийн хэсгүүд нь харьцангуй сул холбоонд байгаа учраас зааг нь тодорхой, бие даасан байдалтай, өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбоонд суурилсан.</p> <p>г. Өгүүлбэрүүдийн байрыг сольж байрлуулах боломжтой</p> <p>д. “бол” холбоос нь нөгөө талаас ялгах, салгах, эсрэгцүүлэх утга үүрэгтэй. Үүнийг ойролцоо задлаг шинжтэй холбох хэрэглүүрээр сольж үзвэл “Тус орны баруун хэсэгт мөнх цас, мөсөн голтой өндөр уулс сүндэрлэж байхад зүүн хэсэгт нь тал газар үргэлжилдэг” гэж холбож болно. Мөн “ба, бөгөөд, харин” г.м.-ээр солих боломжтой байдаг нь зэрэгцүүлэх утга үүрэгтэй байгааг батална. (жишээ нь: Хүмүүс бишүүрхэн харж байхад, харин гоёж гоодсон охин нь Дүгэртэй хамт усны суваг дээр ичингүйрэн сууж байна.)</p> <p>е. НӨ-т хоёр үйл байдлыг эсрэгцүүлэн тавихын зэрэгцээ бас харьцуулан жишсэн утгыг гаргаж байна.</p> <p>Ингэж ЗНӨ-т эсрэгцүүлэн тавьж, харьцуулан жишсэн утга илтгэхээс гадна үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй НӨ-т ч адил байна. Жишээ нь: Сая гаруй хүн амтай Лидс хэдэн жилийн өмнө том том үйлдвэрийн утаанд хахаж цацан байсан бол одоо утаа тортоггүй цэвэр сайхан хот болжээ. (сониноос) г.м.</p> <table border="1" data-bbox="479 787 1242 892"> <tr> <td rowspan="2">“бол”</td> <td>“∅ + бол” (нийлэг)</td> <td>угсруулах холбоонд суурилсан</td> </tr> <tr> <td>“бол + ∅” (задлаг)</td> <td>зэрэгцүүлэх холбоонд суурилсан</td> </tr> </table> <p>“Үүнээс болоод эхний жил –улирлын дүн гарах бүр Дарам, Дэрэм хоёрын хооронд маргах, мэтгэлцэх, тэр ч байтугай хэрэлдэх явдал ч үе үе гардаг байв. (Д.М) гэсэн НӨ нь цагийн БГӨ-тэй, олон ТоГӨ-тэй бөгөөд “тэр ч байтугай” гэсэн холбоос нь зэрэгцүүлэх холбоон дээр хэрэглэгдэж, ахиулах, лавшруулах, онцлон чухалчлах утгыг илтгэж байна. Жишээ нь: Би үнэндээ даарах байтугай сэтгэл зүрхэнд гал шатаж, бүх бие бадайран халууцаж байлаа.</p> <p>Зөвлөмж Холбох хэрэглүүр нь бүлэглэх, зэрэгцүүлэх, эсрэгцүүлэх, шалтгаан- үрийн, ахиулах, лавшруулах, үе өгүүлбэрийн утгыг эргүүлэх, дугаарлах, салгах, нэгтгэн ерөнхийлсөн г.м. утгыг зааж, хэлж бичиж буй хэсгүүдийн авцалдааг нарийн болгох, өгүүлэгчийн хандлагыг илэрхийлэх зэрэг чухал үүрэгтэй. Бичсэн эхдээ сэдэв, агуулга, бүтэц, зөв бичих дүрмээс гадна холбоосуудыг зөв хэрэглсэн эсэх талаас нь заавал шалгуур хийж байх нь чухал юм.</p>	“бол”	“∅ + бол” (нийлэг)	угсруулах холбоонд суурилсан	“бол + ∅” (задлаг)	зэрэгцүүлэх холбоонд суурилсан	
“бол”	“∅ + бол” (нийлэг)		угсруулах холбоонд суурилсан				
	“бол + ∅” (задлаг)	зэрэгцүүлэх холбоонд суурилсан					
<p>11.46. Орон цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэрийн утгыг тодорхойлж, сонгон найруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Цогцолбор болон нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэрээр зааглах - Өгүүлбэрүүдийн төгс бус өгүүлэхүүнд асуулт зохиох, дараагийн ямар гишүүнд ямар утгаар холбогдож байгааг тодорхойлох - Үйлийн зорилго, шалтгааны утга заасан төгс бус өгүүлэхүүнийг олох, дараагийн өгүүлбэртэй хэрхэн, юугаар холбогдсон, түүний утга, үүргийг тодорхойлох, тайлбарлах - Үйлийн зорилго шалтгааны утга заасан бүтээвэр, холбох үгийг эхээс жагсаан бичих, бүлэглэх, тодорхойлох - Үйлийн орон, цагийн утга заасан төгс бус өгүүлэхүүнийг олох, дараагийн өгүүлбэртэй хэрхэн, юугаар холбогдсон, түүний утга, үүргийг тодорхойлох, тайлбарлах - Үйлийн орон, цагийн утга заасан бүтээвэр, холбох үгийг эхээс жагсаан бичих, бүлэглэх, тодорхойлох 	<p>Уншиж судалж буй төрөл бүрийн эхүүд</p>					

	<ul style="list-style-type: none"> - Орон цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэрийн утга, үүргийг харьцуулах, тайлбарлах - Үйлийн цагийн утга заасан бүтээвэр, холбох үгээс сонгон, энгийн өгүүлбэрүүдийг цуваа ба зэрэгцээ цагаар холбох - Үйлийн орны утга заасан бүтээвэр, холбох үгээс сонгон, энгийн өгүүлбэрүүдийг холбох - Үйлийн шалтгаан, зорилгын утга заасан бүтээвэр, холбох үгээс сонгон, үйл явдлыг өрнүүлэн холбох - Үйл ба хэрэг явдлыг орон цаг, зорилго, шалтгаанаар зэрэгцүүлэн тоочихын зэрэгцээ угсруулан өрнүүлж цогцолбор, эхийг бүтээх - Өгүүлбэрт орон цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үгийг оновчтой сонгож найруулсан эсэхийг дүгнэх, сайжруулах <p>Зөвлөмж <i>Багш унших, бичих зорилтын хүрээнд ашиглах эхээс тухайн задлалыг хийж болохоос гадна тухайлан зорилтыг хангах үүднээс тусгай эх, цогцолбор сонгож болно. Харин саланги өгүүлбэрээс илүү эхийн түвшинд задалж ярилцах хэрэгтэй. Өгүүлбэр зүйн задлалыг хийхдээ утгын харьцаанд сайн төвлөрнө. Үйл явдлыг шалтгаан, зорилго, цаг, орноор холбуулаад, найруулгыг засах, өөрөөр хэлбэл үйл явдлыг учир шалтгаанаар зөв нөхцөлдүүлэн холбох дадлагыг хийх хэрэгтэй.</i></p>	
<p>11.4в. Өвөрмөц, хэвшмэл хэлцийг тухайн найруулгад сонгон хэрэглэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эх өгүүлбэрт орсон хэлцийг олох, гол санааг дэлгэрэнгүй тайлбарлан бичих - Өвөрмөц хэлц, хэвшмэл хэлцийг ялгах, харьцуулах, тайлбарлах - Хэлцийн ойролцоо болон эсрэг утгын эгнээ үүсгэх, утгыг харьцуулах - Хэлц нь найруулгад ямар үүрэгтэйг тайлбарлах - Хэлцийг сэдэв, санаагаар бүлэглэх, тэдгээрт монголчуудын ахуй сэтгэлгээний онцлог хэрхэн туссаныг дүгнэж, тайлбарлах - Эх дэх хэлцүүдийг шууд нэрлэлтээр солин найруулах, найруулгад өөрчлөлт гарч байгаа эсэхийг нягтлах - Хэлцийн санаа, хэлбэрийг дуурайн зохиох - Хэлцийг өгүүлбэрт утга санаа зохируулан хэрэглэх <p>Зөвлөмж <i>Хэлний тогтвортой хэлц нэгжүүдийн утга санаа нь ил биш, далд битүү байдаг тул сайтар задалж, ухаарах дасгал дадлага сайтар хийлгэх хэрэгтэй. Хэлцийг эхээс олох, санааг тайлбарлахаар хязгаарлаж болохгүй. Хэлцээс үндэстнийхээ ахуй амьдрал, соёл сэтгэхүйн онцлогийг мэдэх, хэлц нь хэлний дархлаа, охь шим болдгийг ойлгуулах, улмаар яриа бичигтээ тогтмол хэрэглэх дадалтай болоход анхаарах хэрэгтэй.</i></p>	<p>Бат Ирээдүй.Ж Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга, хэрэглээ Уб., 2003 Базаррагчаа .М Монгол хэл 8 Уб., 1999 Базаррагчаа .М Сорил – 2000 Уб., 2000</p>
<p>11.4г. Төрөл бүрийн толь бичгийг зориулалтаар нь хэрэглэх</p>	<ul style="list-style-type: none"> - Толь бичгүүдээс сонгож авсан баримтуудыг харьцуулан, үгийн утгыг хэрхэн тайлбарласныг ярилцах - Үгийн тайлбарыг ажиглаад, тэмдэглэгээний учрыг тайлбарлах - Толь бичиг нь зорилго, үүрэг, ажил байдлын шаардлагаас болж янз бүр байж болох бөгөөд толь бичгийн төрөл, бүтэц, ашиглах аргыг мэдсэнээ бататгах, дасгал ажиллах 	

	<p>Тухайлбал: Тайлбар толиос толгой үгийн үндсэн утга, салаа утга, шилжсэн утгыг ялган таних ажлыг сурагчдаар хийлгэхдээ багш дараах асуултаар чиглүүлж болно:</p> <ul style="list-style-type: none"> • “Бид нар англи хэл суралцаж байна” гэдгийг “Бид нар англи хэл үзэж байна” гэж хэлж болох уу? • Солин найруулахад утга санаа нь өөрчлөгдөж байна уу? • “суралцаж, үзэж” гэдэг хоёр үг үндсэн утгаараа тохирох уу? г.м. <p>Мөн эхэд онцолсон үг нь тухайн эх буюу хам сэдэвтээ үндсэн утга, салаа утга, шилжсэн утгын алинаар орсон болохыг тайлбар толь ашиглан олж тодорхойлох дасгал ажиллуулж болно.</p>	
--	---	--

**МОНГОЛ ХЭЛ
(Сонгон судлах)**

11.2.1 УНШИХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Сонин нийтлэлийн болон эрдэм шинжилгээний найруулгын өгүүлбэр, үг, бүтээврийн найруулгын онцлогийг судалж, харьцуулах</p>	<p>Сонин нийтлэлийн болон эрдэм шинжилгээний найруулгын төрлийн эхийг харьцуулахдаа дараах онцлог шинжийг анхааран, эдгээрийг хэлний нэгжийн түвшинд авч үзнэ. Дараах зүйлүүдийг харьцуулан уншина.</p> <ul style="list-style-type: none"> - Зохиогчийн зорилгыг - Найруулгын төрлийг онцлогийг - Өгүүлбэрийн бүтэц, хэв шинжийг - Үгийн сангийн онцлогийг - Бүтээврийн онцлогийг <p><i>Сонин нийтлэлийн найруулга:</i> Нийтлэлийн хэл найруулгад сонин, нийгэм улс төрийн сэтгүүл, суртал нэвтрүүлэг, радио телевизийн нэвтрүүлэг, баримтат киноны тайлбар, хурал цуглаан, баяр ёслолын элдэв арга хэмжээнд хэлэх үгийн хэл найруулга зэрэг хамаарна.</p> <p><i>Эрдэм шинжилгээний найруулга:</i> Шинжлэх ухааны найруулгад эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэл, реферат, эрдэм шинжилгээнтэй бүтээлийн дүгнэлт зэргийг хамруудалдагбол эрдэм шинжилгээний найруулгад сурталчилгааны өгүүлэл, нийтэд зориулсан товхимол, лекц, эсээ нийтлэлийг багтаан үздэг. Эдгээр бүтээлтэй сурагчдыг танилцуулах замаар найруулгын төрөл бүрийн онцлогтой танилцуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээний нийтлэг найруулгад хамаарах чиглэлээр эрдэм шинжилгээний эх зохиоходадлага ажлыг зохион байгуулах хэрэгтэй.</p>	<p>Сонин нийтлэл, эрдэм шинжилгээний төрөл бүрийн эхүүд</p>

<p>11.16. Эрдэм шинжилгээний найруулга бүхий хялбаршуулсан эхэд дэвшүүлсэн таамаглал, баталгаа нотолгоо, учир шалтгааны дарааллыг олох, тайлбарлах</p>	<p>Эрдэм шинжилгээний эхийг уншаад задлан шинжилгээ хийхийн тулд дараах үйлийн дарааллыг анхаарна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эхэд дэвшүүлсэн таамаглалыг олж дүгнэх 2. Дэвшүүлсэн баталгаа нотолгоог олж тайлбарлах, дүгнэх 3. Учир шалтгааны дарааллыг олж тайлбарлах, дүгнэх <p>Үүний тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Шинжлэх ухааны зохиолын хэсгүүд нь нарийн дэс дараалалтай, өөр хоорондоо утгын нягт холбоотой, учир зүйн дараалал сайтай байгааг нягтлан унших - Учир зүйн холбоо хамаарал хэрхэн илэрч байгааг ажиглах, задлан шинжилгээ хийх - Логик шалтгааны хуулийг анхаарах - Эрдэм шинжилгээний хялбаршуулан найруулга бүхий асуудал дэвшүүлэн эсээ бичвэрийн хувьд сэдэв, эх үндэслэл, эсрэг үндэслэл, шинэ санаа бүхий оюун дүгнэлтийг эрэл хайгуулж хийж унших - Өгүүлбэрүүдийн учир шалтгааны хамаарлыг илрүүлэх - Холбоо хамаарал бүхий холбох үгсийг илрүүлж унших - Догол мөр хоорондын уялдаа холбоог илрүүлж унших, ямар багц санааг илэрхийлснийг тодорхойлох - Бичихдээ догол мөр гаргаж бичихийг ойлгох - Баримт мэдээлэл ба дүгнэлтийг ялгаж унших 	<p>- Л.А. Зенке "Амьтдын амьдрал" - Л.Тарасов "Ертөнцийн тэгш хэмийн гайхамшиг"</p>
<p>11.1в. Сонин нийтлэлийн найруулга бүхий эхийг задлан шинжилж мэдээлэх, нөлөөлөх үүргийг тодорхойлох</p>	<p>Мэдээлэх үүргийг тодорхойлох, тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Сонин нийтлэлийн эхийн гарчгаас юуны тухай мэдээлэх гэж байгааг таамаглах - Эхээс мэдээлэл өгч байгаа баримтуудыг олох - Тэдгээр баримт мэдээлэл нь үнэн бодитой эсэхийг дүгнэх - Эхээс чухал ба чухал бус мэдээллийг ялган тайлбарлах <p>Нөлөөлөх үүргийг тодорхойлох, тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн баримт мэдээлэлд тулгуурлан зохиогчийн үзэл бодол хэрхэн илэрснийг тодорхойлж гаргах - Эхийг уншихад өөрт ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байгаагаа ярилцах - Эхийг итгэл үнэмшилтэй болгож байгаа баримт нотолгоо, үг хэллэг, дүрслэл гэх мэт хэсгүүдийг олж, тайлбарлах - Зохиогч эхээр дамжуулан уншигчдад ямар мэдрэмж сэтгэгдэл төрүүлж байна вэ? түүнийг илрүүлж байгаа үг хэллэг, өгүүлбэр, дүрслэл зэргийг тайлбарлах <p>Зөвлөмж <i>Сонин хэвлэл нь олон түмний мэдээллийн чухал хэрэглүүр болдог бөгөөд тухайн цаг үеийн онцлог бүрэн тусдаг.</i></p>	<p>Сонин нийтлэлийн төрөл бүрийн эхүүд</p> <p>Мэдээ, нийтлэл, аян замын тэмдэглэл</p>

	<p><i>Сонин хэвлэл нь зөвхөн мэдээлэх, дамжуулах учир зүйн тайлбар нотолгоо хийх төдийгүй сэтгэл зүйн хувьд нөлөөлөх үүрэгтэй байдаг.</i></p> <p><i>Сонины мэдээлэх үүрэг нь баримт хэрэглэгдэхүүн яг үнэн зөв байх, албан ёсны шинжтэй байх тодорхой нэгтгэн дүгнэсэн байх сэтгэхүйн хийсвэрлэлт тулгуурласан байх зэргээр илэрнэ.</i></p> <p><i>Сонины хэл найруулгын нөлөөлөх үүрэг нь уриалан дуудах, яруу сайхны таашаалд нийцэх, шинэ үг хэллэгээр илэрхийлэхийг эрмэлзэх, сурталчлан зарлаж таниулах, шинэлэг аястай байх зэргээр илэрдэг. Бичилгийн бусад төрөлтэй харьцуулахад сонины хэл найруулга хамгийн энгийн ойлгоход хялбар, цөөн үгээр өргөн агуулга гаргасан байдгаараа ялгарч байна.</i></p> <p><i>Сэтгэл хөдөлгөх уран үг өвөрмөц хэллэг хэлний яруу хэрэглүүрийг зохистой ашиглавал уншигчдад нөлөөлөх үр өгөөж төдий чинээ их болдог. Уран хэрэглүүрийн үүргээр зөвхөн үг хэллэг хэлзүйн хэлбэр хэрэглэгдээд зогсохгүй сонины гарчиг, догол мөр, бичлэгийн аяс, (товчоолон томъёолох, хүүрнэн өгүүлэх, шүүн хэлэлцэх гэх мэт) оруулсан үгс, ишлэл, түүнчлэн гадаад үг ярианы янз бүрийн хэв маяг орно.</i></p>	
<p>11.1г. Эхийн агуулгын хэсгийг харьцуулах, эсрэгцүүлэх болон шалтгааны утгаар холбон найруулсны учрыг тайлбарлах</p>	<p>Үндэслэл ба нотолгоог судлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлох - Тухайн асуудлын хүрээн дэх зохиогчийн байр суурийг тодорхойлох - Зохиогч өөрийн байр сууриа хамгаалж, үнэмшилтэй болгохын тулд ашигласан баримт нотолгоог олох - Тэдгээр баримт нотолгоог ямар эх сурвалжаас авсныг тодорхойлох - Зохиогчийн асуудалд хандаж буй хандлага, өнгө аяс мэдрэмжээ ямар үг хэллэг, уран тод дүрслэл, баймж үгээр илэрхийлснийг задлан шинжилж тайлбарлах - Зохиогчийн байр суурь, үзэл бодлыг дэмжиж буй шалтгаануудыг гарган, түүний үнэ цэнэ, ашиг тус, давуу ба сул талыг тодруулж дүгнэх <p>Шалтгаан ба үр дагаврыг судлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд ямар нөхцөл байдал, хэрэг явдлын талаар тусгасныг тодорхойлох - Тухайн хэрэг явдал, нөхцөл байдал үүсэх болсон шалтгааныг тодорхойлох - Тухайн шалтгаанаас үүдэж ямар ямар үр дагавар гарсныг тодорхойлох - Түүнд нөлөөлсөн хүчин зүйлс байгаа эсэхийг нягтлах - Зохиогч тухайн шалтгаан ба үр дагаврыг уялдаа холбоотой бичихдээ ашигласан холбох хэрэглүүрийг тодорхойлж, тайлбарлах - Учир шалтгааны холбоос (... иймээс, ийм болохоор, учир нь учраас, ... аас шалтгаалан (хамааран), ... тай холбогдуулах, ... энэ тохиолдолд, ийм нөхцөлд, тийм тохиолдолд ..., Хэрэв ... бол, тэгвэл) - ыг хэрэглэсэн байдалд дүгнэлт гаргах - Зохиогч нэг шалтгаан, нэг үр дагаврыг бичсэн үү, эсвэл олон шалтгаан олон үр дагаврыг бичсэн үү гэдгийг ажиглан загварчлах - Эхэд ашигласан баримтыг олж, шалтгаан ба үр дагаврыг нотлоход ямар үүрэгтэй байгааг дүгнэх 	<p>Эрдэм шинжилгээний эхийн жишээн дээр</p>

	<p>Харьцуулах эсрэгцүүлэх аргыг судлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд дэвшүүлсэн асуудлыг тодорхойлох - Дэвшүүлсэн асуудлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэхдээ юуг юутай харьцуулсныг тодорхойлох - Харьцуулж буй зүйлийн төстэй болон ялгаатай талыг хэрхэн тусгасныг жагсаах - Харьцуулж буй зүйлийнхээ нэг юманд байгаа бүхэллэг шинжийг ижил төстэй шинжтэй харьцуулан багцлах, эсвэл нэг зүйлд нь байгаа нэг өвөрмөц шинжийг нөгөө юманд байгаа ижил шинжтэй хэсэглэн харьцуулах байдлаар санаагаа цэгцтэй илэрхийлэх - Санаагаа дэмжихэд ашигласан жишээ, баримт нотолгоог олж, үүргийг тодорхойлох - Харьцуулж, эсрэгцүүлж бичихдээ цогцолбор болон өгүүлбэрүүдээ холбосон арга хэрэглүүрийг олж, тайлбарлах (Гэвч, гэтэл, харин, ... төдийгүй, тэгсэн төдийгүй, Хэрэв тийм бол, Нэг талаас, нөгөө талаас, харин ч, Иймээс, ийм байдлаар, иймэрхүү, Тэрчлэн, түүнчлэн, үүнчлэн, энэчлэн, түүн шиг, энэн шиг, үүн шиг гэх мэт) - Эсрэг ойлголтыг харьцуулан бичсэн эсэх - Зохиогчийн үзэл бодол, дүгнэлт хэрхэн илэрснийг тодорхойлж тайлбарлах 	
	<p>Үндэслэл ба нотолгоог судлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхэд ямар асуудал дэвшүүлснийг тодорхойлох - Тухайн асуудлын хүрээн дэх зохиогчийн байр суурийг тодорхойлох - Зохиогч өөрийн байр сууриа хамгаалж, үнэмшилтэй болгохын тулд ашигласан баримт нотолгоог олох - Тэдгээр баримт нотолгоог ямар эх сурвалжаас авсныг тодорхойлох - Зохиогчийн асуудалд хандаж буй хандлага, өнгө аяс мэдрэмжээ ямар үг хэллэг, уран тод дүрслэл, баймж үгээр илэрхийлснийг задлан шинжилж тайлбарлах - Зохиогчийн байр суурь, үзэл бодлыг дэмжиж буй шалтгаануудыг гарган, түүний үнэ цэнэ, ашиг тус, давуу ба сул талыг тодруулж дүгнэх <p>Зөвлөмж</p> <p><i>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид эрдэм шинжилгээний хялбаршуулсан эхийг уншаад шалтгаан үр дагавар, үндэслэл нотолгоо, харьцуулах эсрэгцүүлэх утгатай холбох арга хэрэглүүрийг ашиглан эхийн агуулга, бүтцээ хэрхэн уялдаа холбоотойгоор зохион байгуулж, илэрхийлснийг судлан дүн шинжилгээ хийнэ. Эдгээр холбох хэрэглүүрүүд нэг эхэд бүгд орсон байх нь ховор учраас тухай бүрийн онцлогийг илэрхийлсэн эх сонгон ажиллах нь үр дүнтэй.</i></p>	

БИЧИХ:**Гурав. Бүтээлчээр бичих**

Эргэцүүлсэн эсээ, аян замын тэмдэглэл, шинжлэх ухааны хялбаршуулсан эхийг бичих

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа:	Хэрэглэгдэхүүн
<p>11.2а. Эрдэм шинжилгээний хялбаршуулсан эх зохиохдоо агуулгын хэсгийг харьцуулах, эсрэгцүүлэх болон шалтгааны утгаар холбон найруулах</p>	<p>Шалтгаан болон үр дагаврыг тодорхой бичихийн тулд Бичихийн өмнө</p> <ul style="list-style-type: none"> - Ямар нөхцөл байдал, хэрэг явдлын талаар бичихээ сонгох: Жишээ нь: Агаарын бохирдол яагаад үүссэн бэ? - Сурагчдын өвлийн амралтыг сунгах боллоо. гэх мэтээр - Сонгосон хэрэг явдал, нөхцөл байдал үүсэх шалтгаан нь юу байсныг тодорхойлох - Түүнд нөлөөлсөн зүйл байгаа эсэхийг эргэцүүлэх - Тухайн шалтгаанаас үүдэж ямар үр дагавар гарсныг тодорхойлох <p>Бичихдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Дэвшүүлсэн санаа, хэлэлцэх асуудлаа тодорхой гаргах - Тухайн асуудалтай холбоотой мэдээлэл цуглуулах (интернэт, номын сан, төрөл бүрийн судалгаа, шинжилгээ, танилцуулга) - Шалтгаан болон үр дагаврыг уялдаа холбоотойгоор гаргаж, үндэслэлтэй, өрнөлтэй бичих. Ингэхдээ асуудлын шинж чанар, цар хүрээ ямар байна вэ?, ямар учир шалтгаанууд байна? Хүмүүст яаж нөлөөлж байна вэ? гэх зэрэг асуултыг өөртөө тавьж үйл явдлыг товчоолсон, дэс дараалсан байдлаар тайлбар хийх - Асуудлаа дүгнэсэн төгсгөл хийх <p>Бичсэний дараа:</p> <ul style="list-style-type: none"> - Бичсэнээ дахин уншиж дараа шалгуураар шалгах <ul style="list-style-type: none"> ✓ Учир шалтгаан, үр дагаврыг уялдаа холбоотой бичсэн эсэх ✓ Учир шалтгааны холбоос (... иймээс, ийм болохоор, учир нь учраас, ... аас шалтгаалан (хамааран), ... тай холбогдуулах, ... энэ тохиолдолд, ийм нөхцөлд, тийм тохиолдолд ..., Хэрэв ... бол, тэгвэл) - ыг оновчтой сонгосон эсэх ✓ Хэлэх гэсэн чухал санаагаа бүгдийг оруулсан эсэх ✓ Зохиомж, найруулгын хувьд сонирхолтой, үнэмшилтэй байгаа эсэх ✓ Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдааг нягтлан дахин сийрүүлэн бичих <p>Харьцуулж эсрэгцүүлж бичих Бичихийн өмнө</p> <ul style="list-style-type: none"> - Бичих сэдэв, асуудлаа тодорхой болгох - Тухайн бичих зүйлийнхээ онцлогийг эргэцүүлэх - Бичих зүйлийнхээ онцлогийг тодруулахын тулд түүнтэй гол шинжээрээ ижил төстэй зүйлтэй харьцуулах <p>Бичихдээ</p> <ul style="list-style-type: none"> - Бичих сэдвийн талаар шаардлагатай суурь мэдээллийг тусган сонирхолтой байдлаар эхлэх (анхаарал татах асуулт, эшлэл, товч хүүрнэл гэх мэт) - Харьцуулж буй зүйлийнхээ төстэй болон ялгаатай талын тухай үндсэн санаагаа тодорхой гаргах - Харьцуулж буй зүйлийнхээ нэг юманд байгаа 	<p>Шинжлэх ухааны хялбаршуулсан эх</p> <p>Эсээ</p> <p>А.Цог-Очир., Д.Эрдэнэсан “Монгол хэлний эхийн хэв маяг”. УБ., 2015.</p>

	<p>бүхэллэг шинжийг ижил төстэй шинжтэй харьцуулан багцлах, эсвэл нэг зүйлд нь байгаа нэг өвөрмөц шинжийг нөгөө юманд байгаа ижил шинжтэй хэсэглэн харьцуулах байдлаар санаагаа цэгцтэй илэрхийлэх</p> <ul style="list-style-type: none"> - Эш татаж, жишээ дурдах зэргээр санаагаа дэмжиж баяжуулах - Санаагаа товч оновчтой дүгнэх <ul style="list-style-type: none"> - Тухайн харьцуулсан хоёр зүйлийн давуу ба сул талуудын тухай өөрийн үнэлгээ шийдвэрээр төгсгөх <p>Бичсэний дараа:</p> <ul style="list-style-type: none"> - Бичсэнээ дахин уншиж дараа шалгуураар шалгах - Эсрэг ойлголтыг харьцуулан бичсэн эсэх - Ойролцоо ойлголтыг жишиж бичсэн эсэх - Жишиж, харьцуулж буй ойлголтууд нь учирзүйн холбоотой эсэх - Оновчтой жишээ баримт ашигласан эсэх - Өөрийн үзэл бодол, үнэлэлт дүгнэлтээ илэрхийлж эсэх - Бичвэртээ харьцуулах, эсрэгцүүлэх холбоос (Гэвч, гэтэл, харин, ... төдийгүй, тэгсэн төдийгүй, Хэрэв тийм бол, Нэг талаас, нөгөө талаас, харин ч, Иймээс, ийм байдлаар, иймэрхүү, Тэрчлэн, түүнчлэн, үүнчлэн, энэчлэн, түүн шиг, энэн шиг, үүн шиг)-ыг тохируулах хэрэглэсэн эсэх - Зохиомж, найруулгын хувьд сонирхолтой, үнэмшилтэй байгаа эсэх - Найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдааг нягтлан дахин сийрүүлэн бичих <p>Зөвлөмж</p> <p>Шалтгаан болон үр дагаврыг бичих: Шалтгаан болон үр дагаврыг бичихдээ нөхцөл байдал, хэрэг явдал, зан байдлын шалтгаан үр дагаврыг оруулж болно. Бичихдээ яагаад гэдгийг тайлбарлаж үр дүнг тайлбарлаж бичнэ. Шалтгаан ба үр дагаврыг тайлбарлан бичнэ гэдэг нь учирзүйн холбоо сүлбээтэй олон асуудлыг эргэцүүлэн бодох, нэг зүйлийг олон талаас үзэх үзэл хандлагатай ихээн холбоотой ойлголт юм. Хамгийн чухал нь байгаль дэлхий, хүн, амьтан, үйл явдлын логик холбоо сүлбээнээс шалтгаан, үр дагаврын холбоотой байж болох асуудлыг олж уялдаа холбоотой бичих юм. Шалтгаан үрийн холбоог бичих хэд хэдэн арга байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Нэг шалтгаан, нэг үр дагаврын харьцааг гаргаж тайлбарлах 	
<p style="text-align: center;">Навч яагаад унадаг вэ?</p> <p>Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог мөхлөг нь задардаг. Навчны эсийн дотор улаан шар өнгөтэй будагч бодис үлдсэнээс навч улайх ,шарлах зэргээр хувирна. Хүйтрэхэд ургамал хөрснөөс ус авах нь багасна. Түүнчлэн навч хөгширдөг. Энэ үед навчны эсэд ургамлын амьдралд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр хуримтлагдсанаас навч унадаг.</p> <p>Ямагт навчтайгаа байдаг ургамлыг мөнх ногоон ургамал гэдэг. Тэдгээр ургамлын навчны зарим нь унаж байхад шинэ навч ургаж байдгаас мөнх ногоон харагддаг байна.</p> <p style="text-align: right;">/Д. Базаррагчаа/</p>		

	<p>Шалтгаан: Навчны эсэд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр хуримтлагдсанаас</p> <p>Үр дагавар: Навч унадаг.</p> <p>Ийм эх нь ихэнхдээ шинжлэх ухааны тайлбарууд, ертөнцийн юмс үзэгдлийн тухай байдаг. Эхэндээ таамаг төдий зүйл байснаа туршилт судалгаагаар нотлогдсон гол төлөв байгалийн шинжлэх ухаантай холбоотой эхүүд байдаг учраас нэг гаргалгаа, нэг үр дүнг шаарддаг. Шалтгаан үрийн холбоог гаргахдаа гол төлөв “яагаад гэвэл, учраас” гэсэн холбоосыг хэрэглэдэг.</p> <ul style="list-style-type: none"> • Хэд хэдэн шалтгаан, хэд хэдэн үр дагаврын харьцааг тайлбарлах <p>Олон шалтгаанаас нэг үр дагавар гарахыг тайлбарлах нь ертөнцийг олон ургалчаар үзэх үзэл төлөвшин тогтохтой шууд холбоотой.</p> <p>Учир шалтгааны тайлбарыг гаргаж бичих үед олон шалтгаанаас үүссэн нэг үр дагаврыг холбоог учирзүйн алдаагүй, үндэслэлтэй, баримт нотолгоотой, нарийн уялдаа холбоотой бичих аргад сурахад энэ чадварын мөн чанар оршино. Энэ нь цаашлаад хувь хүнд аливаа зүйлд ул суурьтай, олон талаас нь хандаж дүгнэлт хийдэг хандлагатай болох суурь болно.</p> <p>Энэ талаар жишээ баримт, тайлбарыг А.Цог-Очир., Д.Эрдэнэсан “Монгол хэлний эхийн хэв маяг”. Уб., 2015. Номын 56-68 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.</p> <p>Харьцуулж эсрэгцүүлж бичих : Ихэвчлэн тайлбарласан эсээ бичихэд энэ аргыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл нэг зүйлийг нөгөөтэй харьцуулж тайлбарласан харьцуулал байна гэсэн үг. Хоёр зүйлийн ижил ба ялгаатай талыг жишиж, харьцуулж бичдэг. Өгүүлж буй юм, хэрэг явдлын тухай хэрхэн өгүүлэхээс шалтгаалж харьцуулах 2 арга байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Бичиж буй асуудлын хүрээн дэх бүхий л зүйлийг харьцуулах:</i> Үүнийг ерөнхийд нь харьцуулах гэнэ. Энэ аргыг хэрэглэвэл зохиогч нь сэдвийн эргэн тойронд буй бүх нарийн ширийн зүйлийг судлах шинжлэх шаардлагатай болдог. • <i>Аль нэгэн онцлог шинжийг сонгон бичиж тайлбарлах:</i> ингэж бичихэд сэдвийн хүрээн дэх ойлголтуудаас аль нэг онцлог шинжийг сонгоод нөгөө сэдвийн өөр нэг онцлогтой харьцуулж тайлбарладаг. <p>Харьцуулан эсрэгцүүлж бичихэд харьцуулж, жишиж буй ойлголт нь логикийн холбоотой байх, сонгож буй үг хэллэг нь утга, өнгө аясын хувьд хоорондоо зохицсон байх дүгнэлт нь харьцуулж, жишиж буй зүйлээсээ улбаалан гарсан бичигчийн цоо шинэ үзэл бодол, үнэлгээ байх гэх мэт зүйлийг анхаарах шаардлагатай. Иймээс харьцуулан бичих түгээмэл аргуудад суралцах тэдгээр аргыг ашиглан бичсэн эх уншиж задлан шинжилгээ хийх нь чадвараа сайжруулахад ач холбогдолтой.</p>	
	<p>Мэдээллийг цэгцэлж, баримт нотолгоонд үндэслэн дүгнэж, тулгуур бичиглэл хийж сурахын тулд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эхэд өгүүлэгдэж буй гол ойлголтуудыг жагсаана. Ойлголт тус бүрийг гурваас цөөн үгээр илэрхийлнэ. Ойлголт ухагдахууныг ихэвчлэн нэр томъёо, нэр 	

<p>11.26. Мэдээллийг цэгцэлж, тулгуур бичиглэл хийх</p>	<p>үгээр томъёолно. Эхлээд бүх ухагдахуунаа дэс дараалал харгалзахгүйгээр жагсааж бичнэ. Эсвэл жижиг карт хэлбэрийн цаасан дээр тус бүрийг нэг цаасан дээр бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 2. Ухагдахууныг ерөнхийгөөс тусгай руу шилжүүлэн ангилна. Хуудасны дээд талд гол ойлголтыг томоор бичнэ. Хамгийн жижиг тусгай нарийвчилсан ойлголтыг доод талд бичнэ. Үлдсэнийг цаасны голд бичнэ. 3. Жагсаасан үгсийг утгаар нь хооронд нь холбож зурна. Тэдгээрийн хоорондын уялдаа холбоог илэрхийлж болох цөөн тооны холбоос, төлөөний үг, үйл үгийг нэмж бичиж болно. Гэхдээ энэ нь маш цөөн байна. 4. Хийсэн тулгуур бичиглэлээ хянана. Энд нэг ухагдахууныг давтсан эсэх. Хэрэв давтсан бол уул эхэд нэг ойлголт, нэг санааг давтсан байж магадгүй тул эхийн найруулгыг ажиглаж дүгнэнэ. Мөн ямар нэг чухал ойлголтыг орхисон байж болох тул түүнийг хянана. Мөн холбоос хэрэглүүрийг хянана. 5. Ийнхүү тулгуур бичиглэлээс дүгнэлт өгүүлбэр, цогцолборыг гаргаж болно. 6. Сурагчид өөрсдийн бичсэн эхийг энэ аргаар хянах нь бичиж буй зүйлийнхээ “усыг шахах” үр дүнтэй арга болдог. <p>Хэрэг явдалд өөрийн болоод бусдын үзэл бодлын үүднээс хандан дүгнэж өгүүлэхэд түгээмэл хэрэглэх холбоос нь: Минийхээр, миний бодвол, миний санахад, түүний жишээлдгээр бол, цаг уурын мэдээгээр бол, энэ номд дурдсанаар, түүний үзэж байгаагаар г.м. холбоосыг дүгнэлтэд хэрэглэж болно.</p>	
<p>11.2в. Эхийн найруулгын төрөл, бүтэц, хэв маягийн онцлогт тохируулан өгүүлбэр, үг, бүтээврийг сонгон найруулах</p>	<p>Эрдэм шинжилгээний эх зохиох үйлийн баримжаа эзэмших</p> <ul style="list-style-type: none"> - Эх зохиохын өмнө холбогдох ном бүтээлтэй сайн танилцах - Баримт цуглуулах - Баримт нь гол санааг илэрхийлэхэд тус болохуйц байх - Багш зөвхөн цуглуулсан баримтыг үзэж хэр бүтээлч хандсан эсэхэд үнэлгээ өгч болно - Бүх баримтыг биш, чухал ач холбогдолтойг нь сонгон боловсруулалт хийх - Бүтээлийн эхний ноорог хийхийг зөвлөх - Дэлгэрэнгүй байж болно 	
<p>11.2г. Эхийн бүтэц, агуулгыг өөрчлөн найруулж бичих</p>	<ul style="list-style-type: none"> - Хувиргах эх бичвэрээ сонгож, унших - Эхийн утга (Эхийн сэдэв, хэрэг явдал, гол ба далд санаа, дүрслэл, зохиогчийн зорилго, хандлага өнгө аяс) бүтэц (дүрийн бүтэц, зохиомжийн бүтэц)-ийг Хэн? яах гэж? ямар маягаар? гэсэн асуултад хариулж шинжлэх - Тухайн эхийн утгыг яах гэж? ямар маягаар өөрчлөн бичих вэ? гэдгээ төлөвлөх - Төлөвлөснийхөө дагуу ноороглох - Сайжруулах - Сийрүүлэх - Анхны эх зохиолтой харьцуулан бүтэц, агуулга хэлбэр хэр өөрчлөгдсөнийг дүгнэх 	<p>Хүүрнэмж эх</p> <p>Дүрслэн тоочсон эх</p> <p>Тайлбарламж эх</p> <p>Эргэцүүлэмж эх</p>

- Үнэлгээ өгөх замаар санал солилцох

Зөвлөмж

Энэ хувиргалтыг хийхдээ тухайн хувиргах гэж байгаа эхээ уншиж, утгыг ойлгох хэрэгтэй. Үүний дараа тухайн эхийг яах гэж? ямар маягаар өөрчлөх вэ? гэдгээ бодож төлөвлөнө. Яах гэж? гэдэг асуулт бол чиний бичих зорилго гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин ямар маягаар гэдэг бол хэн гэдэг дүрээр дамжуулж, ямар бүтэцтэй, дүрслэлтэй, ямар утга санаа бүхий ямар үйл явдлыг бичих вэ? гэдэг асуудал юм.

Өөрчлөн бичсэн эхийг анхны эх бичвэртэй заавал харьцуулж, үнэлгээ хийнэ. Тиймээс багш тодорхой шалгуур гаргаж, түүнийгээ бичихээс нь өмнө өгвөл үр дүнтэй байх нь бий. Учир нь хүүхдүүд юуг? Яаж хийвэл хэрхэн үнэлэгдэх вэ? гэдгээ мэдэхэд, нөгөө талаар энэ шалгуур нь бичих чиглэл болж өгдөг. Жишээ нь иймэрхүү шалгуур гаргаж өгч болох юм.



Шалгуур	Үзүүлэлт
Сэдэв, агуулгыг гаргасан байдал	Төлөвлөгөөний дагуу бичсэн байх
	Бүтцийн хэсгүүдийг зөв гаргасан байх
	Бичлэгийн төрөл, хэлбэр, хэв байх
	Сэдэв санаанд тохирсон хэрэг байх
Найруулсан байдал	Үгийг оновчтой сонгосон байх
	Хэлзүйн бүтээврийг оновчтой сонгож байх
Бичгийн соёлоо харуулсан байдал	Зөв бичих дүрэм болон цэг тэмдэгт хэрэглэж байх
	Хичээнгүй, цэвэр, гаргацтай бичих

Оноог багш өөрөө өгнө. Шалгуур үзүүлэлтүүдээс юуг нь онцгойлон анхаарч үзэх вэ? гэдгээс хамаарч оноогоо өөр өөрөөр өгч болно. Ерөнхийдөө бичих чадварыг үнэлэхдээ нийт 20 оноо байхаар тооцож, түүнийгээ маш нарийн шалгуур үзүүлэлтээр гаргаж, онооны задаргааг хийж өгөх хэрэгтэй. Ингэж хийх юм бол таны зааж сургаж буй хүүхдүүд тань бичихэд хэрэгтэй чадваруудаас юун дээр нь сайн, юун дээр нь хангалттай, юун дээр нь хангалтгүй байна гэдэг нь тодорхой харагдах бөгөөд сурагчдад, эцэг эхчүүдэд зөвлөгөө мэдээлэл өгөхөд хамгийн чухал “feedback” байх болно.

Түүнчлэн эхийг бичих зорилгыг өөрчлөхөд анхаарлаа хандуулаарай. Тэгэх юм бол үгийн сонголт, хэлбэр хэв маяг, дүр, дүрслэл, бичигчийн өнгө аяс, хандлага хүртэл өөрчлөгдөж харагдана.

Яах гэж /why/? (мэдээлэх, ятган итгүүлэх, сэтгэлийг татах, сургамж санаа өгөх, нөлөөлөх гм) ямар маягаар? /how/ (хэлбэр хэв маягийг дуурайгаад агуулгыг өөрчлөх, агуулгыг эсрэгцүүлэх, мэдээлсэн эхийг дүрслэн тайлбарласан болгох, дотоод бүтцийг шалтгаан-үр, асуудал-шийдэл, харьцуулах-эсрэгцүүлэх, тоочин дүрслэх зэргээр, гадаад бүтцийн үргэлжилсэн хэлбэрийг шүлэглэсэн болгох, эхлэл, гол төгсгөл хэсгийг тонгоргох) гэх мэт маш олон янзаар хувиргуулж болно. Гэхдээ ямар маягаар бичихийг сурагчдаар сонголт хийлгэх хэрэгтэй. Ингэвэл бичлэгийн олон янз /загварт болон чөлөөт/-ын хэлбэрээр нэг санааг гаргаж болдгийг хүүхдүүдэд харуулах боломжтой юм. Эндээс хүүхдүүдийн чөлөөт сэтгэлгээ, баригдмал бус байдлыг харах боломжтой юм.

СОНСОХ – ЯРИХ

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.3а. Хэлэлцүүлэг, мэтгэлцээний явцад асуудлын мөн чанарыг эргэцүүлж, эерэг байр суурь, шинэ санааг дэмжих, үндэслэлтэй баримтаар нотолж дүгнэх</p>	<p>Энэ зорилтын хүрээнд сурагчид санаа бодлоо баталгаа нотолгоотой илэрхийлэх чадварт суралцана. Дараах аргаар асуудлын мөн чанарыг тогтоож болно. Асуудлын мод арга “Асуудлын мод” аргын тайлбар: Асуудлын мод арга нь асуудлыг үүсгэж буй нөхцөл, үр нөлөөг бүх талын хүчин зүйлийг тодорхойлон авч үзэх боломжийг олгодог бүтээлч сэтгэлгээний аргын нэг юм. <i>Ажиллах аргачлал:</i> Дэлгэцийн том цаасан дээр ургаж байгаа мод зурна. Модны их биед АСУУДЛАА бичнэ. Энэ асуудалд хүргэж буй хүчин зүйлсийг модны үндэс хэсэгт, асуудлаас үүсэх үр дагаврыг модны мөчрөөр төлөөлүүлэн зурна. Асуудлын мөн чанар гэдэгт шалтгаан, үр дагавар, шийдэх арга замыг ойлгоно.</p> <p>Зураг 1</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <ul style="list-style-type: none"> • Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргын тайлбар: Энэ аргын мөн чанарыг танин мэдэхэд асуудал гэсэн ухагдахууныг тодруулан ойлгох нь чухал. Асуудал бол бэлэн байгаа мэдлэгээ ашиглаад шууд хариулж чадахгүй, ямар нэгэн хэмжээний эрэл, хайгуул, судалгаа, шинжилгээ хийхийг шаардсан хүмүүсийн амьдралд байдаг бэлэн асуулт, баримт юм. Асуудал нь сурагчдын амьдралын туршлага, бодит хэрэгцээнээс урган гарсан байх ёстой. • Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргын үе шатыг тодруулан харуулбал: • Тулгамдаж буй асуудлуудыг тодруулах, тэдгээрийг эрэмбэлэх • Тэдгээр асуудлуудаас хамгийн түрүүнд шийдвэрлэж болох нэг асуудлыг сонгох, олон өнцгөөс харж, өөрийн хувилбаруудыг дэвшүүлэх, шийдлийг ярилцах • Асуудлыг судлах аргаа сонгох • Сонгосон аргаараа асуудлаа судлах 	

	<ul style="list-style-type: none"> • Судалсан үр дүнгээ танилцуулах.¹ <p>Эерэг байр суурь, шинэ санааг дэмжих, үндэслэлтэй баримтаар нотолж дүгнэх</p> <p>Нотолгоо: Нотолгоо дэвшүүлэх замаар тухайн шийдлээр таны баримталж байгаа байр суурь хамгийн зөв гэдгийг шүүгчид итгүүлэх арга юм. Өөрөөр хэлбэл өөрийн байр суурийг зөв гэдгийг батлах үндэслэлүүдийг шүүгчид гаргаж өгнө гэсэн үг. Нотолгоо нь сул эсвэл хүчтэй байх нь бий. Мэтгэлцээний үед таны нотолгоо хамгийн сайн нь гэж шүүгчид итгүүлж чадах хамгийн хүчтэй, хамгийн үнэмшилтэй сайн нотолгоог дэвшүүлэх хэрэгтэй. Эсрэг талын довтолгоог давж гарч чадах хүчтэй нотолгоог шүүгчид үнэлдэг.</p> <p>Дэмжлэг: мэтгэлцэгч нотолгооноос гадна өөрсдийн үндэслэлийг хамгаалах, дэмжих баримтыг шүүгчдэд өгөх шаардлагтай. Нотолгоог биет дэмжлэг баримт үнэмшилтэй болгодог.</p> <p>Нотолгоо дэвшүүлэх арга</p> <ul style="list-style-type: none"> • <i>Адилтгалаас нотолгоо дэвшүүлэх нь: Хоёр талын адил талд тулгуурласан адилтгал ба жишээлбэл, А ба Б нь адил учраас А-ийн хувьд үнэн байгаа зүйл Б-ийн хувьд ч үнэн гэж нотлох юм</i> • <i>Жишээлсэн нотолгоо дэвшүүлэх нь: Ямар ч маргаангүй гэж үзэгдэх жишээ татаж улмаар нөгөө зүйлийг үүнтэй яг адил гэж үзсэний үндсэн дээр дүгнэлт хийх юм.</i> • <i>Шалтгаан ба үр дагаварт үндэслэсэн нотолгоо: Шалтгаан ба үр дагаврын нарийн анализд түшиглэдэг.</i> • <i>Нэр хүндтэй эх сурвалжид найдах: Кейсээ итгэл үнэмшилтэй болгохын тулд эрдэмтэн шинжээчдийн дүгнэлтэд хандах нь бий.</i> • <i>Баталгааг бий болгох: Үндэслэлд тулгуурлан мэдэгдэлд хийх ба, баталгаа нь мэдэгдлийг дэмжсэн мэдээлэл ба мэдлэгийг хүлээн зөвшөөрөх шалтгааныг бий болгодог.</i> <p>Солбисон асуултын тухай</p> <p>Мэтгэлцээний явцад нэг ба хоёрдугаар илтгэгчдээс эсрэг багийн гишүүн асуулт асууж хариулт авах үеийн солбисон асуултын үе гэдэг.</p> <p>Солбисон асуултын зорилго:</p> <p>Мэтгэлцээний үед солбисон асуулт дараах үүрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> • <i>Эсрэг багийн баримталж буй байр суурийг тодруулах үе Тодорхойлолт болон нотолгоо нь хэтэрхий өргөн хүрээтэй бол нөгөө тал нарийвчлах хэрэгтэй</i> • <i>Эсрэг талын алдаа сул талыг илрүүлэхэд чиглэж болно. Кейст агуулагдаж буй зөрчлийг шууд харуулах боломжтой юм. Эцэст асуулт асуугч өөрийн талын байр суурийг дэмжсэн хөрс суурийг бий болгоход анхаарна.</i> <p>Асуулт тийм үгүй гэсэн хариулт авахааргүй байх ёстой. Асуулт асуухдаа мэтгэлцэгч эхлээд хоёр талын санал нийлж буй байр суурийг бий болгодог ба дараа нь талуудын баримталж буй байр суурийн ялгаатай талуудыг тодруулахад чиглэсэн асуултыг асуудаг тактик бий.</p> <p>Асуултад хариулах сурагчид анхааралтай болгоомжтой хандах хэрэгтэй. Тухайн асуултын үр нөлөөг нягтлан үзсэний дараа аль болох тодорхой шууд хариулт өгөх нь зүйтэй. Асуултад бүрэн</p>	
--	--	--

¹ Гомбожав Г. Асуудал шийдвэрлэх сургалт УБ., 2009. 121-р тал

хариулах ёстой ба гэхдээ хэт дэлгэрэнгүй байх шаардлагагүй. Асуултад хатуу байр суурь баримтлахаас айх хэрэггүй. Тодорхойгүй ойлгомжгүй асуултыг тодруулах хэрэгтэй.

Дасгал:

- *Гурав гурваараа баг болох (Нотлох, няцаах, шүүх)*
- *Шийдлийг авч үзье. Шийдсэн нь: Хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг уламжлалт 180 өдөр байгааг 210 өдөр болгож, уртасгах нь зүйтэй.*
- *Нотлох тал: Шийдлийг дэмжсэн нотолгооны санааг боловсруулж эхлэх ёстой. Эхлээд хэрэгцээ шаардлагыг нь бодож үз. Хичээлийн жил илүү урт байх ямар хэрэгцээ шаардлага байна вэ?*
- *Няцаах тал: шийдлийг няцаасан нотолгооны санааг боловсруулж эхлэх ёстой. Эдгээр нотолгоо нь тухайн шийдлийг ерөнхийд нь сэргэсэн эсвэл нотлох талын кейсийг тусгайлан няцаасан байна.*
- *Шүүх тал. Хугацаа болон илтгэх дарааллыг хянаж, илтгэгч бүрийн гаргасан нотолгооны байдлаа үндэслэн ялагчийг тодруулна.*
- *Нэгэнт шийдвэр гарсны дараа, мэтгэлцэгчдэд яагаад ийм шийдвэр гаргаснаа тайлбарлана.*
- *Илтгэлийн дараалал дараах байдалтай байна.*
 - Нот3 мин
 - Няц 3 мин
 - Нот 1 мин
 - Няц 2 мин
 - Нот 1 мин
 - Шүүгчийн шийдвэр

Нот эхэлж болон төгсгөлд ярих боломжтой байх нь чухал. Түүнчлэн хоёр талын илтгэх хугацаа нийлбэрээрээ адил байх ёстой.


Зөвлөмж

Мэтгэлцээн нь зөвхөн сайн муу ба үнэн худлыг шүүх болон баримт ба үзэл бодлын зөрчлийг илрүүлэхэд чиглэдэггүй. Мэтгэлцээн нь үнэт зүйл ба зарчмуудын зөрчилт талуудыг нээн авч хэлэлцэхэд чиглэдэг. Мэтгэлцээн нь аливаа зөрчлийн мөн чанарыг илрүүлэхэд чиглэдэг. Тэгэхээр мэтгэлцээний явцад зөрчлийн уг шинжийг нээх явдал чухал байдаг. Ямар нэгэн үнэт зүйлийг тусад нь авч үзсэн тохиолдолд түүний үнэ цэн тодорхой байдаг бол хоёр үнэт зүйл зөрчилдөхөд аль нь илүү үнэ цэн бүхийг батлах сонгох шаардлага гарна. Энэ тохиолдолд хүмүүсийн хооронд саналын зөрөлдөөн гарна. Улмаар асуудлыг аль аль талаас нь авч үзэх хэрэгцээ гарна. Энэ нь мэтгэлцээн өрнөх үндэс болно. Мэтгэлцэгчид шийдлийг хоёр талаас нь авч үзсэнээр нэг асуудлыг янз бүрээр, олон талаас нь харж болохыг ойлгодог юм. Ингэснээр сурагчид үзэл бодлоо шүүн тунгаах шүүмжлэлтэй хандах боломжтой болдог. Улмаар сурагчид амьдралдаа өнгөц хийсвэр бус, харин ул суурьтай үндэслэлтэй шийдвэр гаргаж сурахад нөлөөлдөг.

Эсрэг талын санаа бодлыг өөрчлөх нэг арга зам бол байр суурийг нь нягтлан үзээд үндэслэлтэй үнэмшилтэй няцаах явдал юм. Сурагчид аливаа асуудлыг хоёр талаас нь авч үзэхийн давуу талыг ч ойлгодог.

Асуудлын зөрчилдөөнтэй талуудыг нэгбүрчлэн авч үзсэнээр практик шийдэлд хүрэх болно.

Боловсролын мэтгэлцээн нь оюун ухааныг хөгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд бодит оршин байгаа асуудлуудыг

	<p>шүүмжлэлтэйгээр авч үзэж зөрчилдөөн үүсэж буй суурь зарчмуудыг ойлгож сурна. Зөрчилдөж буй зарчмуудын мөн чанар, үнэт чанарыг цэгнэж сурдаг ба нотолгоо дэвшүүлэх болон хоосон цэцэрхэх хоёрын ялгааг олж хардаг.</p> <p>Өгөгдсөн шийдлийг зөвшөөрсөн эсвэл няцаасан баримт тохиолдлыг дэвшүүлэхэд хариулт шаардлагатай гэж үзсэн цуврал болон багц асуултуудыг өөртөө тавих замаар шийдэлтэй холбоотой асуулдлуудыг олж болох юм.</p> <p>Эерэг байр суурь шинэ санааг дэмжих Мэтгэлцэгч нь алдаатай бодлогыг хөхүүлэн сайшаах, эсвэл хэзээ ч үнэлэгдэхгүй сөрөг зүйлсийг хамгаалан дэмжих ёсгүй. Үндэслэлтэй баримтаар нотолж дүгнэх Мэтгэлцэгч нь “амны зоргоор ярих албагүй</p> <p style="text-align: center;">Мэтгэлцээний бүтэц</p> 	
--	---	--

ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.4a. Нийлмэл өгүүлбэрийг задлан шинжлэх</p>	<p>Нийлмэл өгүүлбэрийг задлан шинжлэх нь өгүүлбэр зүйн үндсэн асуудал болох холбох ёс, холбох хэрэглүүрт суурилсан, доод түвшний нэгж нь дээд түвшний нэгжээ бүтээсэн шинжтэй, тодорхой эрэмбэлэгдсэн чанартай байдаг. Иймээс ЭӨ-тэй НӨ-ийг жишин үзвэл шинжүүд нь илүү тодорхой гардаг. ЭӨ-үүд өгч НӨ бүтээлгэж, ярилцах, улмаар ЗНӨ, УНӨ, ХЗНӨ, гэ-т НӨ –ийг задлан шинжилнэ. Жишээ нь:</p> <p>Хонх дуугарав. Хичээл эхэллээ. (ЭӨ-үүд)</p> <ol style="list-style-type: none"> 1. Хонх дуугарч, хичээл эхлэв. 2. Хонх дуугарсан ба хичээл эхлэв. 3. Хичээлд хэн сайн оролцоно, тэр сайн ойлгоно. 4. Хичээл эхэлмэгц чимээ намдав. 5. Хэрэв хичээлд сайн оролцох юм бол багш урмаар шагнана. 6. Хичээлд хэн сайн оролцвол тэр сайн сурна. 7. Хичээл үргэлжилж байгаа учир хүүхдүүд завгүй байна. 8. “За, та нар ойлгов уу” гэж багш асуув. 9. Багш асуунгаа самбарт тайлбарлана. 10. Багшийн тайлбарлахыг хүүхдүүд анхаарна. 11. Хүүхдүүдийн идэвхтэй оролцсон нь багшийн хичээлийн бэлтгэл сайн байсных юм. 12. Хичээл дуусахтай зэрэг Бат нэг санал гаргав. 13. Хичээл тарахлаар ангиараа кино үзье гэж Бат хэлэв. 14. “Ээ гялай, ээ гялай” гэж Болор хашгирав.г.м. <p>эдгээр янз бүрийн бүтэцтэй өгүүлбэрүүдийг ажиглахад төгс ба төгс бус байдлаараа, өгүүлбэрүүдийн зааг нь тод ба</p>	<p>Ц.Өнөрбаян нар “Орчин цагийн монгол хэл” (2010)</p> <p>М.Базаррагчаа “Монгол хэл” (2000)</p> <p>Б.Пүрэв-Очир “Монгол хэлний өгүүлбэрзүй” (1998)</p> <p>А.Цог-Очир нар “Монгол хэлний эхийн хэв маяг” (2015)</p> <p>Б.Чимгээ нар “Монгол хэлний гарын авлага” (2012)</p>

салгахад нягт бат байгаа эсэхээрээ, холбосон хэрэглүүрүүд нь өөр өөр байгаагаараа, гол гишүүдийн хэлбэржилт зэргээрээ ялгаатай байгааг задлан тайлбарлана.

Нийлмэл өгүүлбэр нь гурав ба түүнээс дээш хэсэгтэй байвал олон төвтэй гэх ба энэ тохиолдолд 4 төрлийн нийлмэл өгүүлбэр (ЗНӨ, ХЗНӨ, УНӨ, гэ-т НӨ) янз янзын байрлал, холбоогоор хосолж, холимог бүтэц үүсгэдгийг тодорхой ялган задлуулснаар олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр, холимог нийлмэл өгүүлбэр, гэ-т нийлмэл өгүүлбэр зэрэг бүтцүүд үүсдэг болохыг ойлгуулна.

Зөвлөмж

Нийлмэл өгүүлбэрийг задлан шинжлэх нь өгүүлбэрзүйн үндсэн асуудал болох холбох ёс, холбох хэрэглүүрт суурилсан, доод түвшний нэгж нь дээд түвшний нэгжээ бүтээсэн шинжтэй, тодорхой эрэмбэлэгдсэн чанартай байдаг. Энэ талаар “ОЦМХ” (2010) номоос тодорхой үзэж болно. Иймээс ч өгүүлбэр задална, тодорхойлно гэдэг бол өгүүлбэрзүйн үндсэн асуудлын эрэмбээр хэлний тодорхой нэг баримт дээр шат дараалсан, шинжилгээг хийж байгаа тийм үйл ажиллааны арга барил юм. Дараах зүйлс бол нийлмэл өгүүлбэр задлан шинжлэхэд хамгийн чухал юм.

- *Өгүүлбэрийн доторх үгсийг аймаг, хэлзүйн хэлбэр, утгын талаар нь таньж, шинжилгээ хийнэ. Үгсийн аймгийг буруу таньж, үгийн бүтэц, нөхцөлийн утгыг мэдэхгүйгээс болж буруу тодорхойлоход хүрдэг.*
- *Өгүүлбэр дэх үгсийн холбоог олох нь зөв задлах түлхүүр юм. Үгсийн холбоог олохдоо өгүүлбэрийнхээ эхнээс ч хийж болно, хойноос ч холбон олж болно. Өмнөөс олох нь захирагдсан үгийг захирсан үгэнд нь тохож олох арга бол хойноос олох нь захирсан үгээс захирагдсан дагуулыг нь олох арга юм. Ингэснээр өгүүлэхүүн төв тогтоох, гол ба гишүүн өгүүлбэрийн зааг, утгыг тодорхойлох нөхцөл болно.*
- *Чөлөөт бус тогтвортой холбоо үгийн шинжилгээ хийх. Өгүүлбэрзүйд үг гэж үзэх, гишүүн гэж үзэх нь ялгаатай зүйл бөгөөд нэг үг нэг гишүүний үүрэгтэй байхад гурван үг нийлээд нэг гишүүн болдгийг сануулах.*
- *Өгүүлэхүүн төвийг тогтоох. (Өгүүлэхүүн нэг төвтэй байвал энгийн, хоёр ба түүнээс дээш төвтэй бол ерөнхий бүтцээрээ нийлмэл өгүүлбэрийн дохио болдог. Хэчнээн үйл үг байна, төчнөөн өгүүлбэр байна гэж үздэг.) Энэ нь ЗНӨ, УНӨ, ОГӨУНӨ, гэ-т НӨ, ХоНӨ –ийн аль нь болохыг ерөнхийд нь таних, холбох хэрэглүүр, утгыг нь мэдэх гол баримжаа болдог.*
- *Гишүүдийг зурах. Нийлмэл өгүүлбэрийн хэсгүүдийг өгүүлбэр өгүүлбэрээр, утгыг нь хөвөөл алдаа гардаггүй. Тухайн нэг өгүүлбэрийг зурахдаа эхлээд өгүүлэхүүнийг нь, дараа нь тэрхүү үйлийг хийж буй эзэн буюу өгүүлэгдэхүүнийг нь олж, улмаар дэлгэрүүлэгч гишүүдийг асуултын зарчмаар хийвэл хялбар байдаг.*

Түүнчлэн а) ингэж, тэгэхлээр, тиймээс, гэтэл, ийнхүү гм. гадаад холбоосын утга үүрэгтэй зүйлийг гишүүн

	<p><i>болгодоггүй. б) Хандсан үг өгүүлбэр нь харилцах түвшний зүйл байдаг тул гишүүн болдоггүй. в) Өгүүлбэрийн бүтцэд үйл үг чухал үүрэгтэй. Тэгвэл огт үйл үггүй өгүүлбэр байж болно. Да.Батбаярын “Дурсамж” зэрэг эх дан нэрлэсэн өгүүлбэрээр найруулж, нэг ч үйл үг хэрэглээгүй. г) Өгүүлбэрийн утгад чухал үүрэгтэй баймж үг нь бие дааж гишүүн болдоггүй, харин өгүүлэгчийн харилцаа хандлага, үнэлэмж заадаг. д) бай-, бол- туслах үйл үг, а-, бө~бү язгуурт дутмаг үйл үг, гэ- язгуурт үйл үгийн зарим хэлбэрүүд нь заримдаа холбох үгийн үүргээр, заримдаа эцсийн байрлалд туслах үйл үгийн үүргээр ордог. Энэ тохиолдолд бие дааж гишүүн болдоггүй, өмнөх үгтэйгээ хамтдаа гишүүн болдог зэргийг ойлгуулах нь зүйтэй.</i></p>	
<p>11.46. Эх, өгүүлбэр зохиохдоо бүтэц, бүтэц бус, энгийн ба нийлмэл өгүүлбэрүүдийг утга төгөлдөр хослуулан найруулах</p>	<p>Өгүүлбэрийг задлан, тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн өгүүлбэрүүдийг энгийн өгүүлбэр болгох - Өгүүлбэр холбох хэрэглүүрийг нэрлэн, утга, үүргийг тайлбарлах <p>Хоёрос дээш хэд хэдэн өгүүлбэрийг ил хэрэглүүр болох үг, бүтээвэр (нөхцөлөөр) холбохоос гадна, тэг үндэс ба тэг холбоосоор холбодог. Нийлмэл өгүүлбэрийг</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэл зүйн бүтээврээр 2. Хэлзүйжсэн үгээр 3. Бие даасан үгээр 4. Төлөөний үгээр 5. Холбох үйл үгээр холбохоос гадна эдгээрийг хослуулан, өгүүлбэрийг холбож болно. <ul style="list-style-type: none"> - Эхийн өгүүлбэрийг бүтэц ба бүтэц бусаар ялгах, утга, найруулгын үүргийг тайлбарлах - Энгийн өгүүлбэрүүд утга агуулгын хувьд ойролцоо, эсрэг алин болохыг тайлбарлах - Ойролцоо ба эсрэг өгүүлбэрийн утга, найруулгын үүргийг харьцуулах, дүгнэх - Өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тайлбарлах - Өгүүлбэрийн баймж, үнэлэмжийг тайлбарлах - Эх ба цогцолборт өгүүлбэр, үг, бүтээврийг хэрхэн төгөлдөр хослуулан найруулсныг жишээгээр батлах - Өгүүлбэрийн утгын бүрэлдүүлбэр болсон чанар, тоо, орон, цагийг илрүүлэх, өгүүлбэрийн үндсэн шинж, үүргийг тайлбарлах <p>Өгүүлбэрийг найруулах</p> <ul style="list-style-type: none"> - Энгийн өгүүлбэрүүдийг нийлмэл өгүүлбэрийн утга санаанд нь зохицуулан холбож, цогцолбор, эх бүтээх, найруулгыг хянах, сайжруулах <p>Эх зохион найруулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> • зөв оновчтой • товч, эмх цэгцтэй • яруу дүрслэлтэй, яруу тодорхой, • энгийн ойлгомжтой <p>Найруулгын алдаа:</p> <ul style="list-style-type: none"> • буруу – дутуу • эмх цэгцгүй – нуршуу • болхи – гажуу • тодорхой бус – зохисгүй <ul style="list-style-type: none"> - Энгийн ба нийлмэл өгүүлбэрүүдийг ойролцоо ба эсрэг 	<p>Уншиж судалж буй төрөл бүрийн эхүүд</p>

	<p>санаагаар утга төгөлдөр хослуулан найруулах, улмаар цогцолбор, эх бүтээх, найруулгыг хянах, сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Бүтэц ба бүтэц бус өгүүлбэрүүдийг холбон найруулах, найруулгыг хянах, сайжруулах - Өгүүлбэрт шинэ санаа, баймж үнэлэмж нэмж, нийлмэл өгүүлбэр, цогцолборыг утга төгөлдөр хослуулан найруулах - Хэлэнд холбож хэлэмгүй утгын зохицлоор өвөрмөц санаа гарган найруулах, өгүүлбэрийн санаа, утга хослолыг ярилцах - Энгийн өгүүлбэрт чанар, тоо нэмэн, утга төгөлдөр хослуулан найруулж, нийлмэл нийлмэл бүтээх, найруулгыг хянах, сайжруулах - Энгийн өгүүлбэрт орон, цаг нэмэн, утга төгөлдөр хослуулан найруулж, нийлмэл өгүүлбэр бүтээх, найруулгыг хянах, сайжруулах - Нийлмэл өгүүлбэрт чанар, тоо, орон, цаг нэмэн, утга төгөлдөр хослуулан найруулж, цогцолбор бүтээх, найруулгыг хянах, сайжруулах - Өгүүлбэрийг дэлгэрүүлэн хувиргах <p>Зөвлөмж <i>Найруулан бичих чадварт сургахын тулд эхийн доторх өгүүлбэрийн бүтцийг ажиглуулах, адилхан бүтэцтэй өгүүлбэр бичүүлэх нь үр дүнтэй байдаг. Бид өгүүлбэрийг зөв найруулах алхмыг алгасаад шууд эх зохиолгох ажлыг хийлгэж эхэлдгээс хүүхдүүд найруулгын талаар тодорхой зөв ойлголт авч чаддаггүй. Өөрөөр хэлбэл, үг оновчтой сонгон, утга шилжүүлсэн дүрслэл бүхий өгүүлбэр зохион эхийг бүхэлд нь зөв найруулж, бичихийн тулд өгүүлбэрийг зөв найруулах алхмыг тусад нь хэд хэдэн удаа хийлгэсний дараа эхээ бичүүлэх хэрэгтэй.</i> <i>Эхээс утгын хувьд төгөлдөр хослуулан найруулсан сонгодог өгүүлбэр цогцолбор олоод тэдгээрийн бүтэц болон түүний дүрслэх ур маяг бүтсэн, баймж үнэлэмжээ илэрхийлсэн аргыг дуурайлгаад, өөрсдийн бичсэнээ эхтэй харьцуулан, найруулгын шаардлагын үүднээс дүгнэх ажил хийж болно.</i></p>	
<p>11.4в. Дагаврын, үг нийлэх, авиа сэлгэх, товчлох зэрэг аргаар үг бүтэхийг мэдэх</p>	<p>Дагаврын аргаар үг бүтэхийг мэдэх</p> <ul style="list-style-type: none"> - Эх болон өгүүлбэрээс дагаврын аргаар бүтсэн үүсмэл үгсийг олох - Үүсмэл үгс нь ямар үгийн аймгийн үг болохыг тодорхойлох (ажилла – үйл үг, ажилтан – жинхэнэ нэр, ажилсаг- тэмдэг нэр гэх мэтээр) - Дагаврын аргаар бүтсэн үгсийг үгийн бүтцээр задалж, бүтээврүүдийг тайлбарлах (ажил- идэвхтэй нэр язгуур, -ла – нэрээс үйл үг бүтээх дагавар гэх мэт) - Язгуурыг идэвхтэй идэвхгүй, нэр үйлийн алин болохыг тодорхойлох - Түгээмэл хэрэглэгддэг дагаврын утгыг мэдэх, тайлбарлах - Үгийн утгын өөрчлөлтийг харж дагаврын утгыг тайлбарлах оролдлого хийх <p>Үг нийлэх аргаар үг бүтэхийг мэдэх</p> <ul style="list-style-type: none"> - Хоёр үг нийлж шинэ үг бүтсэн үгсийг эхээс олох - Тэдгээр үгс зэрэгцэх ба угсрах аргын алинаар холбогдсоныг ажиглаж ангилах, тайлбарлах - Зэрэгцэж бүтсэн үгсийг давтаж зэрэгцсэн, энгийн зэрэгцсэн байдлаар нь бүлэглэх 	<p>Уншиж судалж буй төрөл бүрийн эхүүд</p>

	<ul style="list-style-type: none"> - Угсарч бүтсэн нийлмэл үгсийг ажиглаад хамжих болон найрах аргаар холбогдсоноор нь ангилах - Нийлмэл үгсийн бүтсэн арга болон үгийн аймгийн үүднээс тодорхойлох. Жишээ нь: “идэвх санаачилга” – энгийн зэрэгцээ нэр үг “хоцорч моцор” – давтсан зэрэгцээ үйл үг “бор шувуу” – хамжсан угсраа нэр үг “хянан шалга” найрсан угсраа үйл үг гэх мэт <p>Авиа сэлгэх аргаар үг бүтэхийг мэдэх</p> <ul style="list-style-type: none"> - “барзгар- барзгар, бэрзгэр, борзгор, бурзгар, бөргөр, бүрзгэр, биржгэр”, “гангана-гэнгэнэ-гонгино-гунгана-гингэнэ” гэх мэт авиа сэлгэж бүтсэн үгсийг ажиглаж, утгын ялгааг ярилцах - Эдгээр үгс өөр өөр утгатай биеэ даасан үгс үү, эсвэл ижил утгатай нэг үгийн хувилбар уу? гэдгээр асуудал дэвшүүлж ярилцах - Холбоо үг бүтээж, өгүүлбэрт оруулж утгын ялгааг гарган тайлбарлах, - Дүрслэх болон дуурайх үгс эгшиг сэлгэж утга ялган шинэ үг бүтээдгийг нотлохын тулд дүрслэх үгсийг зурах, авиа дуурайх үгсийг илэрхийлсэн дуу авиа гаргах зэргээр утгын ялгааг гарган тайлбарлах - Дүрслэх болон дуурайх язгуурын бүтэц дэх гийгүүлэгч сэлгэж утга ялган шинэ үг бүтээдгийг жишээнээс мэдэх: Жишээлбэл: “сартай-сарсай”, “шавхий-шалхий-шархий” гэх мэт. - Авиа сэлгэж бүтсэн үгсээр холбоо үг болон өгүүлбэр бүтээж утгын ямар ялгаа гарч байгааг тайлбарлан ярилцах - Авиа сэлгэх аргаар бүтсэн үгсийн сан бүрдүүлэх <p>Товчлох аргаар үг бүтэхийг мэдэх</p> <ul style="list-style-type: none"> - Товчилсон үгсийг ажиглаад ямар үгийн товчлол болохыг сэргээн унших - Үгсийг ямар арга ашиглан товчилсныг тодорхойлох - Үсгээр, үеэр, холимгоор товчлох аргын алианаар нь үүссэн болохыг мэдэх, тайлбарлах - Товчилсон үгийг уншихдаа товчилсон хэвээр шууд унших (МУИС, НҮБ, Монцамэ), товчилсон үг болон үеийг сэргээн унших (УИХ – Улсын Их Хурал, ХЭ - Хэнтий аймаг,) ялгаа байдгийг мэдэж зөв унших - Үсгээр, үеэр, холимогоор товчилсон үгийн сан бүрдүүлэх 	
<p>11.4г. Хэл зүйн найруулгын алдааг тайлбарлах, засах</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол хэлний үг бүтэх ёс, үгийн хэлбэржилт, хэлзүйн хэм хэмжээний талаарх ойлголтоо сэргээн санах, бататгах - Хэлзүйн найруулгын алдааг таних, тодорхойлох - Хэлзүйн найруулгын алдааг залруулах <p>Найруулгын алдааны төрөл зүйлийг тодорхой ялгаж, гарсан шалтгааныг олж сурах нь хэл найруулгаа сайжруулахад нэн тустай зүйл юм.</p> <p>Зөвлөмж</p> <p>Аливаа найруулга нь а. бодит юмс үзэгдлийг оновчтой тусгах, б. бичих хэлэх гэсэн санаагаа эмх цэгцтэй эрэмбэ дараатай илтгэх, в. бичих хэлэх гэсэн санаагаа яруу дүрслэлтэй илэрхийлэх, г. хэлний хэм хэмжээний дагуу хэлэх бичих гэсэн дөрвөн хэв шинжийг агуулсан байдаг. Найруулгын эдгээр шинжийг мартвал уул найруулга нь алдаатай болно.</p>	

	<ul style="list-style-type: none"> ● Жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй холбохдоо өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржүүлэн холбож болохгүй. Жишээлбэл: <i>Эцэг эхэд зөвлөмж, залуу гэр бүлд тусламж</i> гэхгүй, <i>эцэг эхэд зөвлөх дэвтэр, залуу гэр бүлд туслах ном</i> гэх юм уу <i>эцэг эхэд өгөх зөвлөгөө, залуу гэр бүлд зориулав</i> гэх жишээтэй. ● Үйл үгийг нэр үгэнд шууд захируулан холбоо үг үүсгэхгүй, заавал цагт нэрийн дагавар хэрэглэнэ. Жишээлбэл: Өөрчлөн байгуулалт, хүлээн авалт гэх мэт холбоо үгэнд байгаа нэр үгийг цагт нэрээр сольж, өөрчлөн байгуулах, хүлээн авах гэж товч холбоо үг үүсгэх ба гүйцэд болговол, өөрчлөн байгуулах ажил/ үйл явц, хүлээн авах ёслол гэх мэтээр өөрчилж, гурван гишүүнтэй холбоо үг үүсгэн хэрэглэнэ. ● Монгол хэлний үйлдэгдэх хэвийн –гд гэсэн дагавар бүтээврийг харьцангуй бага хэрэглэх уламжлалтай хэдий ч илт олшрох болсон. Иймд уг дагаврыг ямар тохиолдолд хэрэглэдгийг мэдэж байх хэрэгтэй юм. ● Үгийн дагавар нөхцөл илүүдэхээс сэргийлнэ. Жишээ нь: <i>Мэдээллийн нууцлал алдагдах</i> гэхгүй <i>Мэдээллийн нууц задрах</i> гэнэ. <i>Мэргэжлийн бус хүмүүсийн найруулсан</i> гэхгүй, <i>Мэргэжлийн бус хүний найруулсан</i> гэнэ. ● Зайлшгүй шаардлагатай дагавар нөхцөл дутахаас сэргийлнэ. Жишээ нь: <i>Устгах асуудал энэ удаа нэлээд ноцтой бодит яригдаж буй юм байна</i> гэхгүй, <i>Устгах асуудлыг нэлээд ноцтой бодитойярьж буй юм байна</i> гэнэ. <i>Зун намартаа л бие биенийхээрээ очицгоодог</i> гэхгүй, <i>Зун намар л бие биенийхээрээ орж гардаг</i> гэнэ. 	
--	--	--